



**МОНГОЛ УЛСЫН СОЁЛ,
СПОРТ, АЯЛАЛ ЖУУЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН САЙД**

Яамны байр, Денверийн гудамж,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14190
Утас: 26 56 26, Факс: (976-51) 26 56 26
Цахим шуудан: info@moc.gov.mn,
Цахим хуудас: www.moc.gov.mn

2025.02.14 № 01/517

танай _____ -ны № _____ -т

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗАРТ,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАРТ,
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАРТ**

Танай байгууллагаас шилжүүлсэн гомдлын дагуу Биеийн тамир, спортын улсын хорооны үйл ажиллагаанд гүйцэтгэсэн дотоод аудитын хяналт шалгалтын тайлан, дүгнэлтийг хургүүлж байна.

Хувийг Биеийн тамир, спортын улсын хороонд.

Хавсралт^{38..} хуудастай.



14190070171

Р.Д. Цэвэржавын
С. Намсайжавын
Д. Ширэгжавын
Н. Батжүрж
Г. Чижигжүйчийн Тогтнүүжийн
архивийн төслийн
бичигч

З.Доржжавын
С. Батчимбетов
С. Батжүрж
Г. Сүрье
С. Намсайжавын
Д. Ширэгжавын
Н. Батжүрж
Г. Чижигжүйчийн Тогтнүүжийн
архивийн төслийн
бичигч

З.Доржжавын
С. Батчимбетов
С. Батжүрж
Г. Сүрье
С. Намсайжавын
Д. Ширэгжавын
Н. Батжүрж
Г. Чижигжүйчийн Тогтнүүжийн
архивийн төслийн
бичигч

З.Доржжавын
С. Батчимбетов
С. Батжүрж
Г. Сүрье
С. Намсайжавын
Д. Ширэгжавын
Н. Батжүрж
Г. Чижигжүйчийн Тогтнүүжийн
архивийн төслийн
бичигч



СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

Дотоод аудитын нэр: Биеийн тамир, спортын салбарын төсөв,

санхүү, хөрөнгө оруулалтын үр дүн

Хамрагдсан байгууллага: Биеийн тамир, спортын улсын хороо

Шалгалтын тайлангийн код: ХШУДАГ-2024/ДА/18

Аудитын дүгнэлт:

Биеийн тамир спортын салбарын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 10 зорилт 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын гүйцэтгэл нь 2024 оны III улирлын байдлаар 68,871.7 сая төгрөгийн төсвийн зарцуулалт хийж, төлөвлөгөөний хэрэгжилт 88 хувьтай дүгнэгдэв.

Улсын төсөвт батлагдсан Биеийн тамир, спортын салбарын хөрөнгө оруулалтын 20 ажлын худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг 60.0 хувьтай гэж дүгнэв.

Биеийн тамир, спортын улсын хорооны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд 7,959.6 сая төгрөгийн санхүүгийн алдаа дутагдал илэрсэн тул дотоод хяналтыг "Сайжруулах шаардлагатай" гэсэн дүгнэлт өгч байна.

Биеийн тамир, спортын салбарын бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ хийхэд хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлтийг сайжруулж, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг дүгнэн тайлагнаж байх шаардлагатай байна.

Дотоод аудитын хяналт шалгалтаар холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн тул 7.5 сая төгрөгийн нөхөн төлбөрийн 4 акт, 2,507.6 сая төгрөгийн зөрчил арилгуулах 7 заалттай албан шаардлагыг тогтоов.

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	1
1. ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1. Байгууллагын тухай.....	2
2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ.....	2
2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт.....	3
2.3. Аудитын арга, аргачлал	3
2.4. Өмнөх шалгалтын талаар	3
3. ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТӨЛӨВШИЛ	3
3.1. Засаглалын удирдлагын талаар	3
3.2. Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын талаар	4
4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР	4
4.1 Салбарын батлагдсан төсөв, түүний өөрчлөлт	4
4.2 Салбарын төсвийн гүйцэтгэл.....	5
4.3 Төрийн өмчит үйлдвэрийн газрын талаарх мэдээлэл.....	7
5. ДОТООД АУДИТЫН ҮР ДҮН.....	8
5.1 Биеийн тамир, спортын хорооны төсөв, санхүүгийн үр дүн:	8
5.2 Үндэсний шигшээ багийн төсөв, хөтөлбөр арга хэмжээний үр дүн:.....	14
5.3 Олимп, паралимпийг дэмжих зардлын төсөв, хөтөлбөр арга хэмжээний үр дүн:	18
5.4 Салбарын хөрөнгө оруулалтын үр дүн:	19
6. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ	
ТОГТООМЖ, БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ДҮН.....	22
6.1 Салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үр дүн:.....	22
6.2 Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дүн:	23
6.3 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн дүн:.....	24
7. НЭГДСЭН ДҮГНЭЛТ.....	25
9. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ	26

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БТСТХ	Биеийн тамир, спортын тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
ССАЖЗЯ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
БТСУХ	Биеийн тамир, спортын улсын хороо
ХШУДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТХААГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дотоод аудитын дүрэм”-ын 5.1, 5.2, 7.2, 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ССАЖЗ-ын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр баталсан удирдамжийн дагуу ХШУДАГ-ын дарга Д.Түмэндэмбэрэл, шинжээч Ц.Алтанхуяг, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах мэргэжилтэн Б.Мандахмаа нар дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

1.1. Байгууллагын тухай

Байгууллагын регистрийн дугаар 9111891, үндсэн үйл ажиллагааны 100-9000-34033, нэмэлт санхүүжилтийн 100-9000-34434 тоот харилцах дансаар бэлэн, бэлэн бус төлбөр тооцоог хийж иржээ.

Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир спортын үндэсний хорооны даргын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн Б/02 дугаар тушаалаар БТСУХ-ны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдсон О.Баттулга аудитын хамрах хугацаанд нэгдүгээр гарын үсгийг зурсан байна.

БТСУХ-ны даргын 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн Б/31 дүгээр тушаалаар байгууллагын ерөнхий нягтлан бодогчоор томилогдсон А.Өнөрцэцэг 2020 оны мөн үеэс одоог хүртэл 2 дугаар гарын үсгийг зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулжээ.

Тус байгууллага нь 2023 оны болон 2024 оны хагас жилийн санхүү, татвар, нийгмийн даатгалын тайлангуудыг хуулийн хугацаанд нь холбогдох байгууллагуудад гарган өгч баталгаажуулсан.

Бүтэц зохион байгуулалт

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2020 оны 08 дугаар 28-ны өдрийн 39 дугаар захирамжаар Биеийн тамир, спортын улсын хорооны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг баталсан байна.

Биеийн тамир, спортын улсын хороо нь зохион байгуулалтын 8 нэгжтэй буюу 2 газар, 6 хэлтэстэй, нийт 72 орон тоотой.

Аймаг, нийслэлийн Биеийн тамир, спортын газар-22, Дүүргийн Биеийн тамир, спортын хороо -9 нийт орон нутгийн харьяа 31 төсөвт байгууллагад 756 орон тоотой.

Спортын анагаах ухааны, эрдэм шинжилгээний төв УТҮГ нь 23 ажилтны батлагдсан орон тоотой.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 224 дугаар тогтоолоор “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨҮГ-ын бүтцийг 5 алба, 99 орон тоотой баталсан ба 2024 оны жилийн эцсийн байдлаар 38 ажилтантай ажиллаж байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1. Аудитын зорилго:

Биеийн тамир, спортын салбарын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлэх, төсөв санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний хэрэгжилтэд дотоод аудит хийж, бодит нөхцөл байдлыг ТЕЗ-д танилцуулах, цаашид үр нөлөөг нэмэгдүүлэх санал дүгнэлт гарган, зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Хамарсан хүрээ: Биеийн тамир, спортын салбарын 2024 оны III улирлын байдлаарх санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд дотоод аудитыг яамны холбогдох газар, нэгж болон Үндэсний шигшээ баг буюу Биеийн тамир, спортын холбоод зэрэг бусад гэрээгээр ажил гүйцэтгэсэн байгууллагуудыг хамруулан гүйцэтгэсэн.

Хязгаарлалт: Хамрах хүрээний хязгаарлалт байхгүй. Биеийн тамир, спортын улсын хорооны 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн аудитын тайланд тус салбарын төсөөв, санхүүгийн зарцуулалттай холбоотой дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хянасан.

2.3. Аудитын арга, аргачлал

Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, Соёлын сайдын 2022 оны А/118 дугаар тушаалаар баталсан “Дотоод аудитыг гүйцэтгэх аргачлал”-ыг мөрдөж дотоод аудитыг гүйцэтгэсэн болно.

Аудитад дараах хууль эрх зүйн актуудыг шалгуур болгов. Үүнд:

- ✓ Биеийн тамир, спортын тухай
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай;
- ✓ Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- ✓ Төрийн аудитын тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Шилэн дансны тухай хууль;
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль;
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль
- ✓ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- ✓ Нийгмийн даатгалын тухай хууль;
- ✓ Бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт.

2.4. Өмнөх шалгалтын талаар

Биеийн тамир, спортын улсын хорооны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хэрэгжүүлдэг ба тайлант онд төлөвлөгөөт 19 дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн.

Биеийн тамир, спортын улсын хорооны удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас аудитад хамааралтай хяналтыг авч үзэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

3. ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТӨЛӨВШИЛ

3.1. Засаглалын удирдлагын талаар

Биеийн тамир, спортын улсын хороо нь эрхэм зорилгоо “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэл, Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд хамаарах биеийн тамир, спортын салбарын үндсэн зорилт, чиг үүрэг болох иргэд биеийн тамир, спортоор хичээллэх олон талт боломжийг бүрдүүлэх, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх, спортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үндэсний спортын өв соёлыг хамгаалж өвлүүлэх, шинжлэх ухаан, технологийн үр нөлөөг нэмэгдүүлж, спортын ололт амжилтыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хүн амын амьдралын чанарыг сайжруулах зорилтуудыг хэрэгжүүлэхэд мэргэшлийн, цаг үеэл олсон шуурхай бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэхэд оршино.” гэж тодорхойлсон байна.

Үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг спортын холбоодоор гүйцэтгүүлж, мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих, олон улсын туршлага, арга технологийг нэвтрүүлэх, тамирчдын бэлтгэл сургуулилт хийх орчин нөхцөлийг бүрдүүлэх үндсэн чиг үүрэгтэй байна.

3.2. Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын талаар

Биеийн тамир, спортын улсын хорооны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн 3.3.5-д заасны дагуу Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан хэлтэс ажилладаг.

Тус хэлтэс нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд батлагдсан 2 зорилт, 6 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Тухайлбал.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 21 аймаг нийслэл, 9 дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороодын 2024 оны эрсдэлийн үнэлгээ Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу 8 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийхэд өндөр эрсдэлтэй-11, дунд эрсдэлтэй-15 эрсдэл бага-6 байгууллага гэж үнэлэгдсэн.

Төлөвлөгөөний дагуу Архангай, Завхан, Өмнөговь аймгийн Биеийн тамир, спортын газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг гүйцэтгэж, тайлан хүргүүлсэн.

Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5-д заасны дагуу Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын биелэлтэд хяналт тавьж ажилласан. Төвлөрүүлэн захирагчын 2023 оны санхүүгийн тайланд өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 91 хувьтай байна.

№	Шийдвэрийн нэр	Тогтоосон		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
		тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн	
1	Төлбөрийн акт	2	1,190.1	2	915.2	88.3
2	Санхүүгийн аудитын албан шаардлага	5	3,567.45	5	3,480.2	85.3
3	Нийцлийн аудитын албан шаардлага	7	-	7	-	97.1
4	Зөвлөмж	18	-	18	-	92.2

4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

4.1 Салбарын батлагдсан төсөөв, түүний өөрчлөлт

Биеийн тамир, спортын улсын хорооны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардал, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 236,176.5 сая төгрөгөөр тооцон, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. УИХ, Засгийн газраас төсвийн төслийн саналыг 91,584.7 сая төгрөгөөр бууруулан 144,591.8 сая төгрөгөөр салбарын төсвийг баталсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь урсгал үйл ажиллагааны 2024 оны төсвийн төслийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрт батлагдсан 144,591.8 сая төгрөгийг

- Биеийн тамир, спортын улсын хороонд 44,856.1 сая төгрөг,
- спортын салбарын хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж худалдан авах зардалд 72,353.4 сая төгрөг,

- Аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газар, дүүргийн спортын хороодод 26,101.8 сая төгрөг,
- Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвд 1,280.4 сая төгрөгийн төсвийг оны эхэнд хуваарилсан байна.

Салбарын 2024 оны төсвийн төсөл, батлагдсан төсвийн харьцуулсан дүн

№	Үзүүлэлт	2024 оны төсвийн төсөл	2024 оны батлагдсан төсөв	Зөрүү
71701	Биеийн тамир спорт	236,176.5	144,591.8	-91,584.7
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	94,098.5	66,853.8	-27,244.7
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл	23,355.0	20,579.5	-2,775.5
2102	Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл	2,919.4	2,588.7	-330.7
2103	Байр ашиглалттай холбоотой зардал	288.2	226.2	-62.0
2104	Хангамж, бараа материалын зардал	890.0	330.6	-559.4
2105	Норматив зардал	2,542.0	1,967.4	-574.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,538.6	2,475.7	-2,062.9
2107	Томилолт, зочны зардал	273.5	73.6	-199.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	40,069.9	30,669.9	-9,400.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,221.9	7,942.3	-11,279.6
80802	Урсгал шилжүүлэг	5,865.1	5,384.6	-480.5
213	Засгийн газрын гадаад шилжүүлэг	215.0	123.7	-91.3
2131	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,800.0	4,708.8	-91.2
2132	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	455.3	447.6	-7.7
2133	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	394.8	104.5	-290.3
22	Хөрөнгийн зардал	136,212.8	72,353.4	(63,859.4)
2201	Барилга байгууламж	123,580.4	68,142.6	-55,437.8
2203	Тоног төхөөрөмж	12,632.4	4,210.8	-8,421.6

4.2 Салбарын төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 2024 оны III улирлын дүнгээр улсын төсвөөс 78,103.0 сая төгрөгийн санхүүжилт авч 68,871.7 сая төгрөгийг үйл ажиллагаандaa зарцуулж, 9,231.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардал 68,871.7 сая төгрөг буюу 88 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь урсгал төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардал 3,673.7 сая төгрөг, харуул хамгаалалтын зардал 4.4 сая төгрөг, Олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж 9.8 сая төгрөг, алдар цолтой ахмадын урамшууллын зардал 155.0 сая төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал 4.8 сая төгрөг, Үндэсний шигшээ багийн зардал 3,951.6 сая төгрөг, спортын хөтөлбөр арга хэмжээний зардал 1,518.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Салбарын хөрөнгө оруулалт, их засварт 72,353.4 сая төгрөгийн жилийн төсөв батлагдсанаас 20,181.1 сая төгрөгийн санхүүжилтийн эрх нээлгэж зарцуулсан байна.

Салбарын төсвийн гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг зардлын ангилаал тус бүрээр гаргав.

Хүснэгт 1. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	ЭЗ-ийн ангилал	ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ	БАТЛАГДСАН ТӨСӨВ		ГҮЙЦЭТГЭЛ	ХУВЬ
			ЖИЛИЙН	III УЛИРАЛ		
		ТТЗ-ийн НИЙТ ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ	144,591.8	78,103.0	68,871.7	88%
1		Биеийн тамир, спортын улсын хороо	43,364.8	38,681.0	32,091.8	83%
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	4,549.6	3,774.1	2,742.7	73%
2	80219	Харуул хамгаалалтын зардал	55.2	36.8	32.4	88%
3	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	368.2	245.5	264.4	108%
4	80509	ОУ-ын байгууллагын гишүүнчлэл, хураамж	123.7	123.7	113.9	92%
5	80704	Алдар цолтой ахмад настан	313.9	236.3	155.0	66%
6	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	108.6	79.6	4.9	6%
7	82101	Улсын шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих зардал	25,731.0	23,909.3	19,957.7	83%
	2101	Цалин, хөлс нэмэгдэл уралдаан	4,578.9	3,192.0	3,927.4	123%
	2105	Норматив зардал	1,471.5	1,471.5	1,010.8	69%
	2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,434.1	1,275.3	1,135.7	89%
	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний	18,246.5	17,970.5	13,883.8	77%
8	82102	Олон улсын тэмцээн уралдаанд оролцох зардал	953.8	873.2	937.1	107%
9	82103	Олон улсын тэмцээн уралдааны шагнал	2,119.6	1,556.5	1,358.6	87%
10	82104	Дотоодод тэмцээн уралдааны зардал	2,366.7	2,366.7	2,201.0	93%
11	82105	Олимп ДАШТ-с медаль авсан тамирчдын	2,060.1	1,373.4	1,415.9	103%
12	82106	Нийтийн биеийн тамирын арга хэмжээний зардал	859.2	569.8	388.7	68%
13	82109	Допинг эсрэг үйл ажиллагааг дэмжих	1,219.1	1,000.0	797.0	80%
14	82112	Олимп, паралимпийг дэмжих үйл ажиллагаа	2,438.0	2,438.0	1,673.7	69%
15	82114	Тусгай олимп	98.1	98.1	48.9	50%
2	80219	Хөрөнгө оруулалт, ИЗ, тоног төхөөрөмж	72,353.4	20,181.1	20,181.1	100%
3		Харьяа байгууллагууд, аймаг нийслэл	27,686.1	19,240.9	16,598.8	86%
4		Дэмжих сан	1,187.5	-	-	0%

4.3 Төрийн өмчит үйлдвэрийн газрын талаарх мэдээлэл

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 52 дугаар тогтоолын дагуу Булган аймгийн Хангат сумын нутаг дахь “Спортын бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ, “Техник спортын төв” ТӨААТҮГ-ыг нэгтгэн “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ болгон өөрчлөн зохион байгуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 243 дугаар тогтоолоор БНХАУ-ын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа “Буянт Ухаа спортын ордон” ТӨААТҮГ-ын засвар, үйлчилгээний ажлыг дуусгаж, улсын комисс хүлээн авснаар тус газрыг “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ-т нэгтгэн өөрчлөн зохион байгуулсан байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 224 дугаар тогтоолоор “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨҮГ-ын бүтцийг 5 алба, 99 орон тоотой баталсан ба 2024 оны жилийн эцсийн байдлаар 38 ажилтантай ажиллаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “Төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох 20 дугаар зүйлийн 20.1.3 “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасны дагуу тус ТӨААТҮГ нь байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж ТӨБЗГ-ын даргаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2024 он төлөвлөгөө	ГҮЙЦЭТГЭЛ			Хувь
			II улирал	II улирал	IV улирал	
1	НИЙТ ОРЛОГО	4,894.9	2,447.5	828.5	2,004.04	46%
1.1	Үндсэн үйл ажиллагааны орлого	4,894.9	2,447.5	727.6	1,602.9	36%
1.2	Бусад орлого	-	-	100.9	401.06	
2	НИЙТ ЗАРЛАГА	5,222.5	2,611.2	1,493.6	1,910.2	40 %
2.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	4,847.7	2,423.8	1,287.8	1,190.5	36%
2.2	Ерөнхий ба удирдлагын зардал	374.8	187.4	171.8		
2.3	Бусад зардал			34.0	719.5	

ТӨБЗГ-ын 2024 оны 225 дугаар тогтоолоор “Үндэсний Шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ-ын 2024 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот тувшинийг баталсан бөгөөд нийт орлогыг 4,894.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 5,222.5 сая төгрөгөөр, татварын өмнөх ашиг, алдагдлыг 327.6 сая төгрөгийн алдагдалтай байхаар баталсан байна.

Жилийн эцсийн гүйцэтгэлээр 2,004.04 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,910.02 сая төгрөгийн зардал гарган нийт орлогын төлөвлөгөөний биелэлт 46% байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 10-р сарын 02-ны өдрийн А/73 тоот тушаалаар Буянт-Ухаа спортын ордныг нэгтгэн 2023 оны 3 дугаар улирлын тайлангаар “Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв” ТӨААТҮГ-ын санхүүгийн тайланд нэгтгэсэн. “Техник спортын төв”, “Спорт бэлтгэл, сургалтын бааз”, “Буянт-Ухаа спортын ордон” зэрэг байгууллагууд нэгдсэнээр “Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв” ТӨААТҮГ-ын 2024 оны жилийн эцсийн баланс дахь өглөг нь 2,070.8 сая төгрөг төгрөгийн өглөгтэй байна. Энэ нь COVID -19 цар тахлын улмаас Монгол Улсад 2020

оны 01 дүгээр сараас эхлэн бүх төрлийн спортын сургалт, тэмцээн уралдааныг хориглосон
улсын онцгой комиссын шийдвэрүүд үе шаттайгаар хэрэгжиж улмаар байгууллагын үйл
ажиллагаа сүл зогсолтод шилжсэн нь өглөг нэмэгдэх гол шалтгаан болж байгууллагын үйл
ажиллагаа доголдож орлого зогсонги байдалтай болсноор ажилчдын цалин, НДШ, татвар,
газар, цахилгааны өглөгүүд жил дараалан хуримтлагдан нэмэгдсэн байна.

**"ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙН БЭЛТГЭЛ СУРГАЛТЫН ТӨВ" ТӨААТУГ-ЫН
ӨГЛӨГИЙН ЖАГСААЛТ**

д/д	Утга	2024 оны 12 сарын 31
1	Цалингийн өглөг	174.15
2	НДШ өглөг	342.2
3	Татварын өглөг	628.7
4	Дансны өглөг	88.72
5	Ашиглалтын зардлын өглөг	93.23
6	"УБ Менежмент" ХК-ийн өглөг	743.80
НИЙТ ДҮН		2,0701.8

Үндэсний аудитын газраас тус төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны санхүүгийн тайланд гүйцэтгэсэн аудитын тайлангаар 1,887.9 сая төгрөгийн зөрчил арилгуулах 11 албан шаардлага, НДШ, татвар, төлбөрийн 373.6 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулах зөвлөмжийг тогтоосон боловч дотоод аудитын хяналтаар хэрэгжилт хангалтгүй дүгнэгдэв.

5. ДОТООД АУДИТЫН ҮР ДҮН

5.1 Биеийн тамир, спортын хорооны төсөөв, санхүүгийн үр дүн:

Илэрсэн асуудал 1. Байгууллагын нэгжийн дарга нар албан тушаалын тодорхойлолтод заагдаагүй чиг үүргээ хэрэгжүүлэн иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан баталгаажуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 6.6.1-д заасны дагуу төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх зарчимтай байтал БТСУХ-ны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Баттулга нь иргэн, хуулийн этгээдтэй ажил гүйцэтгүүлэх, дэмжлэг үзүүлэх, түрээсийн гэрээ байгуулах зэрэг 126 гэрээг өөрөө баталгаажуулаагүй, байгууллагын нэгжийн удирдлагаар батлуулж төсвийн хөрөнгийг зарцуулсан зөрчил гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д заасан батлагдсан төсөөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих гэсэн заалтыг зөрчиж тус байгууллагын нэгжийн дарга нь 5,444.5 сая төгрөгийн төсвийг өөрт олгогдоогүй албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлэн гэрээ байгуулан зарцуулсан байна.

№	Албан тушаал	Баталсан	
		гэрээний тоо	мөнгөн дүн /сая.төг/
1	Бодлого төлөвлөлтийн газрын дарга О.Гэрэл	11	356.4
2	Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Ж.Баасансүрэн	82	2,371.3
3	Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга О.Баасан	29	2,684.2
4	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Цэрэнболд	4	32.6
	Нийт дүн	126	5,444.5

<u>Шалгуур үзүүлэлт:</u>	<u>Илэрсэн алдаа, дутагдал:</u>
Төсвийн тухай хуулийн 16.5.2-д заасан батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих. Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13. албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах.	БТСУХ-ны зохион байгуулалтын нэгжийн дарга нар албан тушаалын тодорхойлолтод заагдаагүй чиг үүргийг хэрэгжүүлэн 5,444.5 сая төгрөгийн 126 гэрээг удирдлагыг төлөөлж байгуулан баталгаажуулсан.
Шалтгаан	
Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар албан тушаалтны үйлдэл, эс үйлдэл.	
Дүгнэлт: Албан тушаалын тодорхойлолтод заагдаагүй чиг үүрэг гүйцэтгэж гэрээ хэлцлийг баталгаажуулсан тул сахилгын арга хэмжээ тооцох.	
Зөвлөмж:	Төсвийн шууд захирагчийн эрх үүргийг хуулийн хүрээнд эрх шилжүүлэхээс бусад тохиолдолд гэрээ, хэлцлийг нэгжийн даргаар баталгаажуулахгүй байх.

Илэрсэн асуудал 2. Төрийн жинхэнэ албан хаагч үндсэн ажлаас гадуурх ажил үүрэг эрхлэлтийн хязгаарыг зөрчсөн байна.

БТСУХ-нд ажиллаж байсан иргэн З.М-ын гомдолын мөрөөр зарим удирдах ажилтны давхар ажил эрхлэлтийн талаар шалгалтыг хийж, тайлбар авч дүгнэлт гаргасан.

БТСУХ-ны гадаад харилцаа, мэдээлэл технологийн хэлтсийн дарга Г.Оюунбат Монголын ксиангцигийн холбооны удирдах зөвлөлийн даргаар сонгогдон ажиллаж байгааг Улсын бүртгэлийн байгууллага 2009 оны 06 дугаар сарын 22 нд бүртгэсэн баримт байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.18-д заасны дагуу үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх нийтлэг чиг үүргийг зөрчсөн гэж дүгнэв.

Илэрсэн асуудал 3. Олон Улсын хүүхдийн Х наадмын бараа материал, хөрөнгө бэлтгэсэн төсвийг тендер сонгон шалгаруулалт зарлахгүйгээр зарцуулсан байна.

Засгийн газрын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан Олон Улсын хүүхдийн Х наадмыг зохион байгуулахад БТСУХ-ны даргын 2024 оны А/414, А/478 дугаар тушаалаар 594.2 сая төгрөгийн төсөв баталж, зарцуулсан байна. Энэ арга хэмжээний гүйцэтгэлийг хянахад Монголын баг тамирчдын хувцас авах зардалд 61.2 сая төгрөг төсөвлөж, спортын холбоодод тамирчдын тоогоор нэг багц хувцсыг 255.0 мянган төгрөгөөр тооцон шилжүүлж, эдгээр холбоод нь Дэнди вин ХХК-т хувцас захиалахдаа нэг бүрийг нь 245.0 мянган төгрөгөөр тооцон төлбөр төлж, төсөвлөсөн зардлаас 2,310.0 мянган төгрөгийн зөрүү гаргаж зориулалт бусаар зарцуулсан, сайн дурын ажилтны ажлын хөлс, хоолны зардалд 28.0 сая төгрөгийг ахлах ажилтан З.Батбаяр, Г.Анхчимэг нарын хувийн дансаар дамжуулан 50 сайн дурын ажилтанд олгосон байхад хоолны 1.6 сая төгрөгийн зардлыг давхардуулан гаргасан байна.

<u>Шалгуур үзүүлэлт:</u>	<u>Илэрсэн алдаа, дутагдал:</u>
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт	- Олон Улсын хүүхдийн Х наадмын Монголын баг тамирчдын хувцас авах 61.2 сая төгрөгийн зардлыг спортын 11 холбоонд хуваан

<p>өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өргийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.</p> <p>Төсвийн тухай хуулийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;</p> <p>Шалтгаан</p> <p>Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар албан тушаалтны үйлдэл, эс үйлдэл.</p>	<p>шилжүүлж, тендер шалгаруулалт зохион байгуулаагүй, шууд гэрээ байгуулсан.</p> <ul style="list-style-type: none">- Баг тамирчдын хувцас худалдан авах төсөвлөсөн зардлын хэмнэлт 2.3 сая төгрөгийг спортын холбоод зориулалт бусаар зарцуулсан.- Сайн дурын 35 ажилтны 2 удаагийн хоолны 1.6 сая төгрөгийн зардлыг төсвөөс дахин зарцуулж батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан.
--	---

Илэрсэн асуудал 4. Төрийн албан хаагчдад цалин хөлс, нэмэгдлийг илүү, дутуу олгосон байна.

Шалгуур үзүүлэлт:	Илэрсэн алдаа, дутагдал:
<p>Төрийн албаны тухай хуулийн 57.1 Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно.</p> <p>Хөдөлмөрийн тухай хуулийн 2.1.3 гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах;</p> <p>Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллаж байгаа ажилтанд түүний ажилласан хугацааг харгалzan ээлжийн үндсэн амралтын хугацаан дээр нь дараах нэмэгдэл амралт олгоно.</p> <p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалаар баталсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 2.13.Ажилтны ажилласан хугацааг харгалzan ээлжийн нэмэгдэл амралтыг дор дурдсанаар тооцож олгоно:</p>	<p>Хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтнээр 7 хоног ажилласан Б.Б гэдэг албан хаагчид 4 дүгээр сард бүтэн сарын 2,410.3 мянган төгрөгийн цалин хөлс тооцож, 1,643.4 мянган төгрөгийн цалин илүү олгосон байна.</p> <p>Хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн С.Н, спортын мэргэжилтэн М.Г нарын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг илүү тооцож, 474.8 мянган төгрөгийн нэмэгдлийг илүү олгосон байна.</p> <p>Ээлжийн амралтын олговрыг тухайн албан хаагчийн улсад ажилласан хугацааг үнэн зөв тооцоогүй шалтгаанаар 2-оос 6 хоногоор илүү тооцож 3 албан хаагчид 1,185.1 мянган төгрөгийн цалин хөлс илүү олгосон зөрчил илэрлээ</p> <p>Мэргэжилтэн М.Г-ийн долоо хоногийн амралтын өдөр ажилласан 431.4 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг олгоогүй, түүний ээлжийн амралтын 170.0 мянган төгрөгийн олговрыг дутуу олгосон байна.</p>
<p>Шалтгаан</p> <p>Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар албан тушаалтны үйлдэл, эс үйлдэл.</p>	
	<p>Дүгнэлт: Албан хаагчид 3,307.3 мянган төгрөгийн цалин хөлс илүү, 601.4 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс дутуу олгосон тул нөхөн төлбөрийн акт тогтоо.</p>
<p>Зөвлөмж:</p> <p>Цагийн бүртгэл, төрийн алба хаасан хугацааг үндэслэн албан хаагчдын цалин хөлсийг тооцоолж үнэн зөв тайлagnаж байх.</p> <p>Холбогдох албан хаагчдад хууль, журамд заасан амралтын хоногийг зөв гаргаж амралтын олговрыг үнэн зөв тооцож олгож байх;</p>	

Илэрсэн асуудал 5. Илүү цагийн нэмэгдэл хөлсийг журамд заасан хязгаараас илүү, дутуу бодож ялгавартайгаар олгосон байна.

БТСУХ-ны даргын 2024 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн Б/47 дугаар тушаалаар Үндэсний их баяр наадмын өдрүүдэд хариуцлагатай жижүүрийн хуваарийг баталж, нэр бүхий 12 албан хаагчдыг томилсон байна. Эдгээр албан хаагчдаас нэр бүхий 6 ажилтанд Б/49 дүгээр тушаалаар 1,976.2 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон, бусад 6 албан хаагчид илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгоогүй ялгавартай шийдвэр гаргасан байна.

Шалгуур үзүүлэлт:	Илэрсэн алдаа, дутагдал:
Засгийн газрын 2018 оны 382 дугаар тушаалаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын З. Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Илүү цагийн нэмэгдэл хөлс олгох тухай 2024 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн Б/49 дүгээр тушаалын хэрэгжилтийг шалгахад тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрүүлэн 6 ажилтанд 13 цагийн нэмэгдлийг илүү тооцож нийт 215.8 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс илүү олгосон зөрчил илрээ. Энэ нь журмын З дахь заалтыг зөрчсөн тул зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.
Шалтгаан	
Журамд заасан хязгаараас хэтрүүлэн илүү цагийн нэмэгдэл хөлс олгох тушаал боловсруулсан хүний нөөцийн ажилтны буруутай үйлдэл, эс үйлдэл;	
Үр нөлөө	
Цалингийн зардал хэтрэх, өр авлага үүсэх, зориулалт бусаар зарцуулагдах эрсдэл үүсгэсэн.	
Дүгнэлт:	
Илүү цагийн нэмэгдэл хөлс олгох хууль, тогтоомжийг зөрчсөн тул зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.	
Зөвлөмж:	
1. Холбогдох албан хаагчдад журамд заасан хязгаарт багтаан илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгож байх;	

Илэрсэн асуудал 6. Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшууллыг журамд заасан хэмжээнээс илүү бодож олгосон байна.

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн А/149 дүгээр тушаалаар байгууллагын ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулж, 5 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна. Байгууллагын ёс зүйн дэд хорооны дарга Д.Цэрэнболд Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 2.6-д заасны дагуу нарийн бичгийн даргын чиг үүргийг хариуцан ажиллах хуваарийг баталсан. Энэ хуваарийн дагуу дэд хорооны гишүүн Б.Лхагваниам 4, 5-р сард, С.Мөнх-Эрдэнэ 6-р сард нарийн бичгийн даргаар ажилласан байна.

Илэрсэн асуудал 3. Ес зүйн дэд хорооны нарийн бичгийн даргын урамшууллыг илүү олгосон байна.	Шалгуур үзүүлэлт:	Илэрсэн алдаа, дутагдал:
	Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Ес зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 3.8-д заасан 5 болон 7 хүний бүрэлдэхүүнтэй Дэд хорооны нарийн бичгийн даргад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг сар бүр, дарга, гишүүдэд хурал болон бусад арга хэмжээнд оролцсон ирц, идэвх оролцоог харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож, улиралд нэг удаа урамшуулалт олгоно гэсэн заалтыг зөрчсөн байна.	Ес зүйн дэд хорооны гишүүн Б.Лхагваниам_ С.Мөнх-Эрдэнэ нарт нарийн бичгийн даргаар ажилласан хугацааны урамшууллыг олгоходоо дэд хорооны гишүүний урамшууллыг давхардуулан тооцож 660.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.
Шалтгаан		
Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар албан тушаалтны үйлдэл, эс үйлдэл.		
Дүгнэлт: Ес зүйн дэд хорооны гишүүнд 660.0 мянган төгрөгийн урамшууллыг илүү олгосон тул нөхөн төлбөрийн акт тогтоов.		
Зөвлөмж:		
Ес зүйн дэд хорооны ажиллах журмын дагуу нарийн бичгийн даргаар ажилласан гишүүнд урамшууллыг давхардуулахгүйгээр олгож, үнэн зөв тайлагнаж байх.		

**Илэрсэн асуудал 7. Төрийн албан хаагчийн албан томилолтын нөхөн төлбөрийг
журамд заасан анхан шатны баримтын бурдэлгүйгээр олгосон байна.**

Нөхцөл байдал: Тайлант хугацаанд гадаад 6 арга хэмжээнд 25 албан хаагч, 88 тамирчны томилолтын зардалд 199.2 сая төгрөг, дотоод 7 арга хэмжээнд 44 албан хаагчид 101.1 сая төгрөгийн томилолтын зам хоног, байрны зардлыг олгосон байна. Үүнд:

- БНСУ-ын Сеул хотноо 2024 оны 01 дүгээр сарын 17-21-ний өдөр болсон олон улсын хуралд А/10 дугаар тушаалаар БТСУХ-ны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Баттулга, гадаад харилцаа, мэдээллийн технологийн хэлтсийн дарга Н.Оюунбат нарын 4 хоногийн гадаад томилолтын 5,272.4 мянган төгрөгийн зардал.
- Тайланд улсын Бангкок хотноо 2024 оны 03 дугаар сарын 03-07 ны өдөр болсон олон улсын арга хэмжээнд А/91 дүгээр тушаалаар мэргэжилтэн Э.Ундралын ажилласан 5 хоногийн гадаад томилолтын 5,080.7 мянган төгрөгийн зардал.
- БНХАУ-ын Бээжин хотноо 2024 оны 04 дүгээр сарын 18-24-ний өдөр болсон мэргэшүүлэх богино хугацааны сургалтад А/195 дугаар тушаалаар БТСУХ-ны Гадаад харилцаа, мэдээллийн технологийн хэлтсийн дарга Н.Оюунбат нарын 9 албан хаагчийн 5 хоногийн гадаад томилолтын 19,308.2 мянган төгрөгийн зардал.
- Оросын Холбооны Улсын Саха хотноо 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс 7 дугаар сарын 1-ний өдөр болсон “Азийн хүүхдүүд 2024” Олон Улсын хүүхдийн спортын наадамд оролцуулах тухай А/417 дугаар тушаалын дагуу БТСУХ-ны гадаад харилцаа, мэдээллийн технологийн хэлтсийн дарга Н.Оюунбат, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Цэрэнболд нарын 7 хоногийн гадаад томилолтын 15,889.4 мянган төгрөгийн зардал.
- БНФУ-ын Парис хотноо зохион байгуулагдсан “Парис-2024” XVII дахь удаагийн зуны паралимпын наадамд оролцуулах тухай А/496 дугаар тушаалын дагуу Гадаад харилцаа, мэдээллийн технологийн хэлтсийн дарга Н.Оюунбат 2024 оны 08 дугаар сарын 21-ны өдрөөс 09 дүгээр сарын 11-ны өдрүүдэд гадаад албан томилолтоор ажилласан 8,899.3 мянган төгрөгийн зардал.
- Бүгд Найрамдах Казахстан Улсын Астана хотноо зохион байгуулагдсан “Астана-2024” дэлхийн нүүдэлчдийн V наадамд оролцуулах тухай А/547 дугаар тушаалын дагуу 2024 оны 09 дүгээр сарын 08-14-ний өдрүүдэд гадаад албан томилолтоор ажилласан 98 тамирчин, албаны төлөөлөгч нарын 144,760.9 мянган төгрөгийн зардал.
- Баян-Өлгий аймагт А/77 дугаар тушаалаар Тусгай олимпын спортын төрлөөр сургалт, тэмцээнийг зохион байгуулах ажлаар 7 албан хаагчдыг 2024 оны 02 дугаар сарын 28-аас 03 дугаар сарын 02-ны өдрийн хооронд 4 хоног ажилласан 9,768.1 мянган төгрөгийн зардал.
- Баруун болон хангайн бүсийн Биеийн тамир, спортын салбарын албан хаагчдыг чадавхжуулах тухай А/190 дүгээр тушаалын дагуу сургалтын ажлаар 8 албан хаагчдыг 2024 оны 03 дугаар сарын 31-ээс 04 дүгээр сарын 27-ны өдрийн хооронд 8 хоног ажилласан 26,213.1 мянган төгрөгийн зардал.
- Зүүн бүсийн Биеийн тамир, спортын салбарын албан хаагчдыг чадавхжуулах тухай А/231 дүгээр тушаалын дагуу сургалтын ажлаар 6 албан хаагчдыг 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 20-ны хооронд 6 хоног ажилласан 17,709.0 мянган төгрөгийн зардал.
- Төвийн бүсийн Биеийн тамир, спортын салбарын албан хаагчдыг чадавхжуулах тухай А/254 дүгээр тушаалын дагуу сургалтын ажлаар 8 албан хаагчдыг 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 05 дугаар сарын 02-ны хооронд 4 хоног ажилласан 13,749.0 мянган төгрөгийн зардал.

- Архангай аймагт Ахмадын биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулах тухай А/404 дүгээр тушаалын дагуу сургалтын ажлаар 4 албан хаагчдыг 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 05 дугаар сарын 02-ны хооронд 4 хоног ажилласан 18,275.0 мянган төгрөгийн зардал.
- Архангай аймагт болсон Улсын урлаг, спортын II зөвлөгөөнд оролцох арга хэмжээний зардал батлах тухай А/471 дүгээр тушаалын дагуу 15.4 сая төгрөгийн төсөв баталсан. Тус арга хэмжээнд 17 албан хаагч оролцох албан томилолтын 14.4 сая төгрөгийн зардал баталж, зардлыг албан хаагчдын цалингийн харилцах дансанд шилжүүлсэн боловч гүйцэтгэлийн байдлаар 6 албан хаагч энэ арга хэмжээнд оролцоогүй байхад бичиг хэргийн ажилтан Д.Мөнгөнцэцэг, нярав ажилтай Б.Болдтөр нарын харилцах дансанд тус бүр 2.0 сая төгрөг шилжүүлсэн байна.

<u>Шалгур үзүүлэлт:</u>	<u>Илэрсэн алдаа, дутагдал:</u>
Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтооюур баталсан "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 2.6. Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчид томилолтоор ажиллуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр, батлагдсан зардлын төсвийг үндэслэн томилолтоор ажиллах үеийн нөхөн төлбөрийг урьдчилан олгоно гэсэн заалтыг зөрчсөн байна.	Архангай аймагт 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 05-ны өдөр зохион байгуулагдсан Улсын зөвлөгөөнд оролцоо томилогдсон 6 албан хаагч оролцоогүй байхад томилолтын зардлыг нь бичиг хэргийн ажилтан Д.Мөнгөнцэцэг, нярав ажилтай Б.Болдтөр нарын харилцах дансанд шилжүүлж 1.3 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.
Шалтгаан	
Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар албан тушаалтны үйлдэл, эс үйлдэл.	
Дүгнэлт: Төрийн албан хаагчид албан томилолтоор ажиллаагүй байхад томилолтын зардлыг бусад ажилтны харилцах дансанд шилжүүлж 1.3 сая төгрөгийн томилолтын зардлыг илүү зарцуулсан тул нөхөн төлбөрийн акт тогтоов.	
Зөвлөмж:	Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журмын дагуу албан томилолтоор ажилласан албан хаагчийн харилцах дансанд томилолтын зардлыг олгож, үнэн зөв тайлagnаж байх.

<u>Шалгур үзүүлэлт:</u>	<u>Илэрсэн алдаа, дутагдал:</u>
Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтооюур баталсан журмын 2.1. Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөн төлбөр олгоно.	Томилолтын зардал олгосон санхүүгийн баримтын бүрдлийг шалгахад дараах нийтлэг зөрчил гаргасан байна. <ul style="list-style-type: none"> Албан томилолтоор ажиллах үнэмлэхийг бичиж олгоогүй. Томилолтоор ажилласан байгууллагын эрх бүхий ажилтнаар томилолтын хуудсанд тэмдэглэл хийлгээгүй. Албан томилолтоор ажилласан үр дүнгийн тухай тайлан бичээгүй. Албан томилолтын үнэмлэхийг удирдлага хааж баталгаажуулаагүй. Албан томилолтоор ажилласан хугацаанд байгууллагаас олгодог өдрийн хоол, унааны хөнгөлөлтийг давхардуулан олгосон.
Шалтгаан	
Хууль, журамд заасан анхан шатны баримтыг хангуулаагүй, зардлын гүйцэтгэлд хяналт сүл тавьсан санхүүгийн ажилтны буруутай үйлдэл, эс үйлдэл;	
Үр нөлөө	Томилолтын зардлын өр авлага үүсэх, зориулалт бусаар зарцуулагдах эрсдэл үүсгэсэн.

Дүгнэлт:

Албан томилолтын зардлыг анхан шатны баримтын бурдэлгүй олгосон, мөн хууль, тогтоомжийг зөрчиж илүү олгосон тул зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж:

- Албан томилолтын удирдамж, үнэмлэх, томилолтын ажлын тайлан зэрэг анхан шатны баримтын бурдлийг хангаж зардлыг олгож байх;
- Албан томилолтоор ажилласан хугацаанд байгууллагаас олгодог унаа хоолны хөнгөлөлтийг олгохгүй байх;

5.2 Үндэсний шигшээ багийн төсөв, хөтөлбөр арга хэмжээний үр дүн:

Үндэсний шигшээ багийн 27 спортын холбоонд 18,958.4 сая төгрөгийн төсөв хуваарилж, 2024 оны III улирлын дунгээр 14,873.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн зарцуулалтын хэрэгжилт 78.5 хувьтай байна.

№	Хөтөлбөрийн арга хэмжээний нэр	Төсөв	Гүйцэтгэл	хувь
1	ОУ-ын тэмцээн	15,577.2	12,848.6	82.5
2	Дотоод бэлтгэл цугларалт	1,629.5	589.5	36,2
3	Хэрэглэл материал	1,751.8	1,435.0	81.9
		18,958.4	14,873.0	78.5

Илэрсэн асуудал 8. Спортын холбоодоор дамжуулан бараа материал, хөрөнгө бэлтгэхдээ тендер сонгон шалгаруулалтгүй төсвийг зарцуулсан байна.

Спортын холбоодын хэрэглэл материалын зардалд 1,751.8 сая төгрөгийг төсөвлөж гүйцэтгэлийн тайлангаар 1,435.0 сая төгрөгийг холбоодод Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны А/22 дугаар тушаалаар баталсан "Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төслийг сонгох, санхүүжүүлэх журам"-ын дагуу олгосон байна.

Гэхдээ энэ зардлыг гаргахдаа 20.0 сая төгрөгөөс дээш дүнтэй буюу тендерийн хуулийн дагуу тендер шалгаруулалтын аргаар гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг явуулах ёстой боловч ТБОНӨХБАЙХАТ хуулийн "10.2.Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно, мөн хуулийн 10.3.Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэснийг зөрчсөн байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 24.4.Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно гэснийг зөрчиж Спортын холбоодод хэрэглэл материал худалдан авах зардлыг санхүүжүүлэн, шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн байна.

Шалгуур үзүүлэлт:	Илэрсэн алдаа, дутагдал:
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.	- Спортын холбоодын хэрэглэл материалын зардалд 1,751.8 сая төгрөгийг төсөвлөж гүйцэтгэлийн тайлангаар 1,435.0 сая төгрөгийг тендер шалгаруулалт зохион байгуулаагүй, шууд гэрээ байгуулан худалдан авалтыг хийсэн.
Төсвийн тухай хуулийн 24.4.Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно	
Шалтгаан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар албан тушаалтын үйлдэл, эс үйлдэл.	
Дүгнэлт: Тендер зарлалгүй шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 24.4 дахь заалтыг зөрчсөн байна.	

Спортын холбоодод хэрэглэл материалын санхүүжилт олгосон жагсаалт

№	Холбоодын нэрс	Хуваарилсан дүн	Дүн	Шилжүүлсэн огноо	Тайлбар
1	Байт харваа	80,000.0	78,284.1	2024-03-04	A/103 тоот тушаалын зардал
2	Биатлон	80,000.0	63,351.0	2024-07-25	A/449 тоот тушаалын зардал
3	Бокс	80,000.0	72,665.9	2024-07-02	A/442 тоот тушаалын зардал
4	Буудлага	390,000.0	391,914.5	2024-03-07	A/124 тоот тушаалын зардал
5	Жүдо	220,000.0	168,718.8	11/25/2024	A/610 тоот тушаалын зардал
6	Хүндийн өргөлт	180,000.0	179,284.2	2024-04-11	A/89 тоот тушаалын зардал
7	Тэшүүр	20,000.0	23,779.4	2024-04-24	A/187 тоот тушаалын зардал
8	Цана	60,000.0	50,493.5	2024-07-25, 2024-12-26	A/502, A/718 тоот тушаалын зардал,
9	Чөлөөт	220,000.0	220,000.0	2024-04-24	A/144 тоот тушаалын зардал /Дэвжээ /Бүтэн хэрэглэл/
10	ПараБайт харваа	60,000.0	59,976.8	2024-04-24	A/217 тоот тушаалын зардал
11	ПараБочи	-	4,830.2	12/26/2024	A/768 тоот тушаалын зардал
12	ПараБуудлага	60,000.0	-		2024 оны 5 дугаар сард шигшээ багаас хасагдсан
13	ПараЖүдо	20,000.0	-		Санхүүжилт аваагүй
14	Пауэрлифтинг	70,000.0	82,346.8	2024-06-04	A/352 тоот тушаалын зардал
15	ПараЦана /гүйлтийн/	30,000.0	29,763.4	11/5/2024	A/615 тоот тушаалын зардал
16	ПараЦана /уулын/	-	9,625.2	11/25/2024	A/637 тоот тушаалын зардал
	Нийт	1,570,000.0	1,435,033.7		

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн A/24 тоот тушаалаар Үндэсний шигшээ багийн 25 төрлийн багт 61 дасгалжуулагч, эмч, 242 тамирчин нийт 303 орон тоотой 5,148.2 сая төгрөгийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал олгохоор төсөвлөж баталсан.

Шигшээ багийн төрөл бүрэлдэхүүнд Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн A/235 тоот “Тушаалын хавсралтад нэмэлт оруулах тухай” тушаалаар Хоккей төрөл нэмэгдсэн байна.

Дээрх тушаал гарсантай холбоотойгоор Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн A/299 тоот “Үндэсний шигшээ багийн зарим бүрэлдэхүүний цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал гаргах тухай” тушаалаар Хоккейн 3 дасгалжуулагч, 26 тамирчин, Чөлөөт бөхийн(сонгомол) 2 тамирчин нийт 31 орон 342.9 сая төгрөгийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг нэмж баталсан байна.

Нийт дүнгээр Үндэсний шигшээ багийн 26 төрлийн багт 64 дасгалжуулагч, эмч, 270 тамирчинд олгосон цалингийн баримт материалыг хянан, цалингийн тооцооллыг давтан шалгах горимоор хяналт, шалгалт хийхэд 557.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрлээ. Тухайлбал:

Илэрсэн асуудал 9. Спортын холбоодын санхүүжилтэд тавих дотоод хяналт сулаас Нийгмийн даатгал, татварын байгууллагад 367.1 сая төгрөгийн өр төлбөр үүссэн.

Илэрсэн асуудал 1. Нийгмийн даатгал, татварын байгууллагад өр төлбөр үүссэн байна.	
Шалгуур үзүүлэлт:	Илэрсэн алдаа, дутагдал:
<p>Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21.1-д заасан Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө,</p> <p>Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25.1.1-д заасан энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх гэсэн заалтыг зөрчсөн байна.</p> <p>Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам”-ын 4.18.5 Татварын болон нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын татвар, шимтгэлийн өр үүссэн.</p>	<ul style="list-style-type: none">- Үндэсний шигшээ багийн 7 холбооны нийгмийн даатгалын шимтгэлийн 2024 оны 09 дүгээр сарын тайлангийн үлдэгдлээр 157.4 сая төгрөгийн өртэй.- 6 холбоо нь татварын байгууллагад ХХОАТ-ын 2024 оны 3 дугаар улирлын тайлангаар 209.7 сая төгрөгийн өр төлбөртэй- Биатлоны холбооны 2 тамирчинд олгосон 21.6 сая төгрөгийн цалин, хөлсийг нийгмийн даатгал, татварын байгууллагад тайлагнаагүй.
<p>Шалтгаан</p> <p>Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар албан тушаалтны үйлдэл, эс үйлдэл.</p>	
<p>Дүгнэлт: Шигшээ багийн зарим холбоод нийгмийн даатгалын шимтгэл, татварын ногдлыг төсөвт шилжүүлээгүй, 3 улирлын тайлангаар 367.1 сая төгрөгийн өртэй, 2 тамирчинд олгосон 21.6 сая төгрөгийн цалинг нийгмийн даатгал, татварын байгууллагад тайлагнаагүй байна.</p>	
<p>Зөвлөмж:</p> <p>Үндэсний шигшээ багийн цалин олгосон санхүүгийн баримтыг журам, зааврын дагуу бүрдүүлж, нийгмийн даатгал, татварын сутгалыг даатгалын сан, төсөвт хуульд заасан хугацаанд шилжүүлэн тайлагнаасан байдалд хяналт тавьж гүйцэтгэлийн дүнгээр санхүүжилт олгож байх;</p>	
Илэрсэн асуудал 10. Шигшээ багийн тамирчдын цалингийн тооцоо, бүртгэл хөтөллөтийг үнэн зөв тайлагнаагүй 134.5 сая төгрөгийн алдаа гаргасан байна.	
Шалгуур үзүүлэлт:	Илэрсэн алдаа, дутагдал:
<p>Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18.1.Ажил олгогч болон энэ хуулийн 7.2, 7.3, 7.4, 7.5-д заасан даатгуулагч дараах хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө.</p> <p>Хөдөлмөрийн тухай хуулийн 43.2.1-д заасан “гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирсон цалин хөлсийг тогтоосон хугацаанд ажилтанд олгох ... мэдээлэл”</p> <p>Хөдөлмөрийн тухай хуулийн 43.2.7-д заасан “ажилтныг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд албан журмаар даатгуулах, хуульд заасан хэмжээгээр шимтгэл төлөх, тайлагнах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлснийг баталгаажуулах”</p> <p>Хөдөлмөрийн тухай хуулийн 104.3. Ажил олгогч ажилтанд цалин хөлс олгох бүрд тухайн</p>	<ul style="list-style-type: none">- Үндэсний шигшээ багийн 13 холбооны 94 тамирчин, дасгалжуулагчийн цалингаас хуульд заасан даатгуулагчийн төрлийн дагуу ногдуулах НДШ, ЭМ-ийн даатгалын шимтгэлийн хувийг буруу тооцоолж 39.3 сая төгрөгийн илүү суутгасан.- 3x3 сагсан бөмбөгийн үндэсний шигшээ багийн 11 тамирчин, дасгалжуулагчийн Засгийн газраас тогтоосон үндсэн цалинг спортын холбоо илуу дүнгээр тооцож 1.1 сая төгрөгийн цалинг илүү олгосон.- цалинг алдаатай бодсоноос шалтгаалан Биатлон, Хоккейг шигшээ багийн холбооны 20 тамирчинд 5.2 сая

<p>хугацаанд олговол зохих цалин хөлсний бүрэлдэхүүн, суутгалын хэмжээ, түүний үндэслэл, олгосон цалин хөлсний хэмжээг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ</p> <p>Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн A/22 дугаар тушаалаар баталсан "Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам"-ын</p> <ul style="list-style-type: none">3.1.16.татвар, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын албанад өргүй байх;4.6. Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 4.11-т заасан ... хэмнэгдсэн төсвийг ажлын 5 хоногт ... эргэн тушаах...4.12-т заасан цалин, урамшууллыг спортын холбооноос ирүүлсэн үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүний мэдээллийг баталгаажуулан олгоно.4.13. Спортын холбоо нь Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, шилжилт хөдөлгөөн хийсэн талаарх мэдээллийг сар бүрийн 20-ны дотор Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэх үүрэгтэй. <p>гэсэн заалттай нийцэхгүй байна.</p>	<p>төгрөгийн цалин хөлсийг дутуу тооцоолж олгосон.</p> <ul style="list-style-type: none">- Пауэрлифтинг холбооны 6 тамирчин, дасгалжуулагчийн цалингаас гэрээт нягтлан бодогчийн цалин гаргуулах үүднээс 4.4 сая төгрөгийн хууль бус суутгал хийсэн.- Цанын спортын холбоо нь дасгалжуулагчийн орон тоонд 2 тамирчинг сонгон шалгаруулалтгүй ажиллуулж 0.3 сая төгрөгийг илүү олгосон.- Пара Жүдо бөхийн холбоо жирэмсэн болон хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаатай 1 тамирчинд 7.5 сая төгрөгийн цалин үндэслэлгүй олгосон.- Боксын спортын холбоо, 3x3 сагсны холбоод 6 тамирчны орон тоо дутуу байхад 76.7 сая төгрөгийн илүү санхүүжилт авсан.
<p>Шалтгаан</p> <p>Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар албан тушаалтын үйлдэл, эс үйлдэл.</p>	
<p>Дүгнэлт: Шигшээ багийн зарим холбоод тамирчин, дасгалжуулагчийн цалингийн тооцооллыг буруу бодож цалинг илүү, дутуу олгосон, НД-ын шимтгэлийг буруу тооцсон, хууль бус суутгал хийсэн, орон тоо дутуу байхад илүү санхүүжилт авсан зэрэг 134.5 сая төгрөгийн зөрчил илэрлээ.</p>	
<p>Зөвлөмж:</p> <p>Баг тамирчид, дасгалжуулагчдын цалинг хөлсийг Засгийн газраас тогтоосон үндсэн цалингийн хэмжээг зөв баримтлан, холбогдох хууль тогтоомжид заасан шимтгэлийн хувь, суутгалыг хийж үнэн зөв тооцоолж байх.</p> <p>Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, шилжилт хөдөлгөөн хийсэн талаарх мэдээллийг үнэн зөв хугацаанд нь тайлагнаж, бодит гүйцэтгэлээр цалингийн зардлын санхүүжилтийн нэхэмжлэл гаргаж байх.</p>	

Илэрсэн асуудал 11. Кураш бөхийн холбоонд олгосон 349.0 сая төгрөгийн санхүүжилтийн гүйцэтгэлийн тайлан, баримт бүрдэлгүй, энэ төрлийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн нэг жилд 2 өөр улсад зохион байгуулагдсан байдлаар зардал гаргасан байна.

Засгийн газрын 2024 оны 64 дүгээр тогтоолоор Монгол Улсад зохион байгуулагдах олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээний жагсаалтад Кураш бөхийн өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн батлагдсан байна.

Энэхүү тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах зардал батлах тухай БТСУХ-ны даргын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн A/582 дугаар тушаалыг баталж БТСУХ-ноос Кураш бөхийн холбоотой 2024 оны 10 дугаар сарын 08-нд 310 дугаар гэрээ байгуулан 350.0 сая төгрөгийг олгохоор тохирсон байна. Гэрээний дагуу 2024 оны 10 дугаар сарын 24-нд БТСУХ-ны даргын 582 дугаар тушаалын дагуу 300.0 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгосон.

Гүйцэтгэлээр тус холбооноос Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний үр дүнгийн тайлан, санхүүгийн баримтыг БТСУХ-нд ирүүлсэн боловч анхан шатны баримт дутуу шалтгаанаар

буцаасан байна. Тэмцээний гүйцэтгэлийн баримтыг ирүүлэх талаар тус холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Ганбаатарт Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Ж.Баасансүрэн удаа дараа шаардсан боловч баримт ирүүлээгүй, дотоод хяналт шалгалтыг хийх хугацаанд уг тэмцээний санхүүгийн анхан шатны баримт хамрагдаагүй болно.

Мөн Монголын Кураш бөхийн холбоонд АНУ-ын Вашингтон хотод болсон Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний баг тамирчдын нислэгийн зардалд 49,040.4 мянган төгрөгийг БТСУХ-ны даргын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/194 дугаар тушаалын дагуу шилжүүлсэн байна. Энэ тэмцээний гүйцэтгэлийн санхүүгийн баримтыг тус холбооноос тайлагнаагүй байна.

Монголын Кураш бөхийн холбоо нь Монгол Улсад Кураш бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулахад 350.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авахаар гэрээ байгуулж 300.0 сая төгрөгийн санхүүжилт авсан байтал АНУ-д болсон Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох гэсэн зориулалтаар 49.0 сая төгрөгийн санхүүжилт авсан, эдгээр тэмцээний санхүүгийн анхан шатны баримтыг бүрдүүлж өгөөгүй нь төсвийн хөрөнгийг зүй бусаар ашигласан байх магадлалтай, мөн Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн зарчмыг хэрэгжүүлээгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зөрчил илэрч байгаа тул Авлигын эсрэг хуулийн 8.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй гэсний дагуу АТГ-д шилжүүлэн шалгуулах шаардлагатай гэж дүгнэв.

Илэрсэн асуудал 12. Засгийн газрын шийдвэрт батлагдаагүй Колухстил бөхийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд 20.4 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Засгийн газрын 2024 оны 64 дүгээр тогтоолоор Монгол Улсад зохион байгуулагдах олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээний жагсаалтад батлагдаагүй “Колухстил” бөхийн насанд хүрэгчдийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахад 20.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

БТСУХ-ны даргын 2024 оны “Тэмцээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай” А/461 дүгээр тушаалд Монголын Колухстил бөхийн холбоотой гэрээ байгуулж ажиллахыг үүрэг болгосон байхад Монголын бүстэй бөхийн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга Б.Жаргалсайхантай гэрээ байгуулж, 20.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, гэрээ дүгнэж акт үйлдсэн байна. Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн 2024 оны 08 дугаар сарын 15-аас 18-ны өдрүүдэд Улаанбаатар хотод болж 15 улсын 100 гаруй тамирчид, шүүгчид, дасгалжуулагчид, албаны хүмүүс оролцсон тухай тайланг ирүүлсэн байна. Энэ тайланд дурдсан 15 улсын төлөөлөл тамирчдын мэдээллийг хайж нягтлахад Ази болон Африк тивээс оролцсон гадаадын тамирчдын фото зураг, гаргасан амжилтын мэдээлэл олдохгүй байгаа нь ийм улсаас тамирчид оролцоогүй байхаар байна. Мөн “Тэмцээний дэвжээг Хан-Уул дүүргээс Спортын төв ордонд зөөхөд 6.0 сая төгрөг зарцуулж Арвижих Мандал ХХК-нд төлсөн татварын цахим баримтын шаардлага хангахгүй баримт хавсаргасан” бөгөөд тэмцээний бичлэгээс үзэхэд уг тэмцээнд ашигласан дэвжээ нь Спортын төв ордны дэвжээ байх магадлалтай (гомдол гаргасан иргэнээс ирүүлсэн баримтад үндэслэв) төсвийн хөрөнгийг зүй бусаар ашигласан гэж дүгнэж төлбөрийн акт тогтоов.

5.3 Олимп, паралимпийг дэмжих зардлын төсөв, хөтөлбөр арга хэмжээний үр дүн:

Олимп, паралимпийг дэмжих үйл ажиллагааны зардалд 2024 оны 3 дугаар улирлын дүнгээр 1,673.7 сая төгрөгийн зарцуулалт гаргасан байна. Эдгээр зардлыг дэлгэрэнгүй байдлаар харуулбал:

- Шигшээ багийн төрлийн 6 холбоонд 731.5 сая төгрөг;

- Үндэсний шигшээ багуудад дэмжлэг үзүүлэх багийн үйл ажиллагаанд 496.8 сая төгрөг;
- Парис-2024 олимпын наадмын үеэр Монгол улсыг сурталчлах Монгол Хаус төслийн арга хэмжээнд 312.0 сая;
- Парасэлэлтийн тамирчин, багшийн паралимпийн наадамд оролцоход 59.3 сая төг;
- Парис-2024 олимпын наадамд оролцох баг тамирчдыг үдэн гаргах ёслолын үйл ажиллагаанд 16.5 сая төгрөг;
- Үндэсний шигшээ багийн тамирчдын дэмжих багийн ахлагч Ч.Насагтогохын олимпод оролцоход 7.7 сая төгрөг;
- Олимп, паралимпийн штабын ажиллах зардалд 48.3 сая төгрөгийн зардал тус тус зарцуулагдсан байна.

Илэрсэн асуудал 13. Зарим тамирчдад журамд тусгагдаагүй зардлын ангиллаар 137.9 сая төгрөгийн эмчилгээний зардал зарцуулсан байна.

<u>Шалгуур үзүүлэлт:</u>	<u>Илэрсэн алдаа, дутагдал:</u>
Төсвийн тухай хуулийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Монгол улсын сайд, Олимп нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/22 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам”-ын 4.1 Спортын холбоонд улсын төсвөөс дараах санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. 4.1.1.бэлтгэл хийх заал, танхим болон түрээсийн төлбөр; 4.1.2.бэлтгэлийн хувцас; 4.1.3.тэмцээний хувцас; 4.1.4.спортын хэрэглэл материал; 4.1.5.эм витамин, тариа, боолт хэрэгсэл, нэмэлт бүтээгдэхүүн; 4.1.6.эмнэлгийн үзлэг, оношилгоо; 4.1.7.сургалт, сорил, судалгаа; 4.1.8.даатгал; 4.1.9.дотоодын бэлтгэл цугларалт; 4.1.10.гадаадын бэлтгэл цугларалт; 4.1.11. олон улс, тив, дэлхийн тэмцээн, наадамд оролцох зардал 4.1.12. Засгийн газраас тогтоосон цалин, урамшуулал	- БТСУХ-ны даргын тушаалаар Жүдо бөхийн үндэсний шигшээ багийн тамирчин Б.Гончигсүрэнд 45.3 сая төгрөг, Ц.Цогтбаатар 24.7 сая төгрөг, Хүндийн өргөлтийн шигшээ багийн тамирчин М.Анхцэцэгт 40.9 сая төгрөг, Чөлөөт бөхийн шигшээ багийн тамирчин Д.Отгонжаргалд 24.0 сая төгрөгийн эмчилгээний зардал гаргасан
Шалгаан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар албан тушаалтны үйлдэл, эс үйлдэл.	
Дүгнэлт: Шигшээ багийн 4 тамирчинд журамд заагаагүй зардлын ангиллаар зардал гаргаж Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтыг зөрчсөн байна.	

5.4 Салбарын хөрөнгө оруулалтын үр дүн:

Төлөвлөлтийн шаардлага хангагий төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж байгаа нь өртөг нэмэгдэх, хэрэгжилт удаашрах шалгаан болж байна.

Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны даргын /хуучин нэрээр/ 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтын багцад Биеийн тамир, спортын салбарын шилжих хөрөнгө оруулалт -24, шинээр эхлэх -20 арга хэмжээ батлагдаж, тухайн онд 72,353.4 сая төгрөг улсын төсөвт суусан байна.

Тухайн оноос хэрэгжиж эхлэх 91,664.5 сая төгрөгийн 20 төсөл арга хэмжээний тухайд Засгийн газрын 2023 оны 409 дүгээр тогтоолын дагуу сайдын багцаас 10 арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Төрийн худалдан авах ажиллагааны газар /цаашид ТХААГ/-т, 4 арга хэмжээний эрхийг Архангай, Баянхонгор аймгийн болон Нийслэлийн

Засаг даргад шилжүүлсэн байна. Харин үлдсэн 6 арга хэмжээг БТСУХ зохион байгуулахаар төлөвлөгөөг баталсан байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан шинээр эхлүүлэх барилга байгууламжийн 6 нь магадлалаар баталгаажсан зураг, төсөвтэй байх шаардлагыг хангагүй байна. Үүнд:

- Нийтийн биеийн тамирын төвийн барилга /Архангай, Эрдэнэбулган сум, 1, 2, 3, 5, 7 дугаар баг/
- Спорт заалны барилга /Архангай, Эрдэнэбулган сум, Булганхангай хороолол/
- Спорт заалны барилга /Говь-Алтай, Халиун сум/
- Спорт заалны барилга /Дундговь, Луус сум/
- Спорт заалны барилга /Увс, Ховд сум/
- Спорт заалны барилга /Ховд, Мөст сум/

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹, Засгийн газрын 2024 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2.2, 3.2.3.4-т заасан шаардлагыг хангагүй байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төлөвлөлтийн шаардлага хангагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталж байгаа нь батлагдсан төсөвт тааруулан ажлын тоо хэмжээг багасгах, барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, тохижилтын ажил хийгдэхгүй орхигдох, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлийг хүлээж хугацаа алдах зэргээр төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх хүндрэлийн суурь шалтгаан болж байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тухайн жилд санхүүжих дүнг хэрэгжүүлэх хугацаатай уялдуулж төлөвлөөгүй, төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилтийг тэнцүү хуваарилах байдлаар тооцож батлаагүй байна. Үүнд:

Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/-2010

Спорт цогцолбор, 2200 суудал /Дархан-Уул, Дархан сум/-2010

Соёл, спорт цогцолборын барилга /Хөвсгөл, Мөрөн сум/-2019²

Өмнөх онуудад эхлүүлсэн зарим төсөл, арга хэмжээ хэрэгжиж дуусаагүй, гүйцэтгэгч болон захиалагчийн үйл ажиллагаанаас шалтгаалан ажил зогссон байна. Тухайлбал:

Төсөвт тусгаагүй, орхигдуулсан ТАХ-ний хугацаандаа хэрэгжээгүй шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, гэрээг дүгнэн үргэлжлүүлэн санхүүжүүлэх, эсвэл цуцалж хариуцлага тооцох зэргээр цаашид авах хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, шаардлагатай санхүүжилтийг ирэх онуудын төсөвт тусгах замаар хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах шаардлагатай байна.

Энэ оны ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдсан шинээр эхлүүлэх 20 төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан үр дүнг нэгтгэн авч үзвэл:

- ТХААГ нь эрх шилжүүлж авсан 10 төсөл, арга хэмжээний тендерийн сонгон шалгаруулалтыг тус бүр 1-ээс 7 удаа зарлаж гүйцэтгэгчдийг шалгаруулах ажлыг зохион байгуулсан боловч одоогийн байдлаар 6 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байна. Үүнд:

¹ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

² 29.3.5.шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, турван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;

- Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Залуучуудын сургалт, спорт хөгжлийн төсвийн барилгын гүйцэтгэгчээр Си эйч би жи констракшн ХХК шалгарч, 13,143.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан.
- Говь-Алтай аймгийн Халиун сумын Спорт заалны барилгын ажил гүйцэтгэгчээр Ар-ОНГОТ ХХК шалгарч, 1,567.4 сая төгрөгийн гэрээ байгуулсан.
- Сэлэнгэ аймгийн Орхон сумын Спорт заалны барилгын ажил гүйцэтгэгчээр Эко буянт ХХК шалгарч, 1,867.1 сая төгрөгийн гэрээ байгуулсан.
- Увс аймгийн Өмнөговь сумын Спорт заалны барилгын ажил гүйцэтгэгчээр Өлкө констракшн ХХК шалгарч, 1,570.2 сая төгрөгийн гэрээ байгуулсан.
- Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Усан бассейн бүхий цогцолборын барилгын ажлын гүйцэтгэгчээр Тэмээн ХХК шалгарч гэрээ байгуулсан
- Дархан-Уул аймгийн Өвлийн спортын ордон барилгын гүйцэтгэгчээр Хилийн 0119-р анги шалгарч гэрээ байгуулсан

- Архангай аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 2 төсөл, арга хэмжээний ажил зураг төсөвгүй учраас хугацаа алдаж 9-р сард анх зарлагдсан боловч тендерт оролцогч байхгүй шалтгаанаар амжилтгүй болсон.
- Нийслэлийн Засаг даргад эрх шилжүүлж Сонгинохайрхан дүүргийн Өвлийн спортын ордны барилга 3 удаа тендер зарлаж Тотал-Идеал ХХК шалгарч 18,232.5 сая төгрөгийн гэрээ байгуулсан.
- Баянхонгор аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн салбарын тоног төхөөрөмж худалдан авах тендерт Тэнгэрийн Уул ХХК шалгарч 569.5 сая төгрөгийн гэрээ байгуулсан.
- БТСУХ нь барилга угсралтын 2, тоног төхөөрөмж худалдан авах 4, нийт 6 тендерийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөгөө батлагдсан. Гүйцэтгэлээр Дундговь аймгийн Луус сумын Спорт заалны барилга, Биеийн тамир спортын салбарын улсын хэмжээнд худалдан авах тоног төхөөрөмжийн тендерийг 3 багцад, Төв аймгийн БТС-ын салбарын тоног төхөөрөмж, Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Спорт цогцолборын агаар сэлгэлтийн тоног төхөөрөмж худалдан авах 4 арга хэмжээний тендерийг зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.
Харин Ховд аймгийн Мөст сумын Спорт заалны барилга, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Усан бассейн чийрэгжүүлэлтийн төвийн тоног төхөөрөмжийн тендерийг зарлаагүй хүлээгдэж байна.

Салбарын хэмжээнд 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн дүгнэхэд ТХААГ -100 хувь, Архангай аймгийн Засаг дарга -0 хувьтай, Баянхонгор аймгийн Засаг дарга 100 хувьтай, БТСУХ – 66.7 хувьтай, нэгдсэн дүн 60 хувийн биелэлттэй байна.

**Биеийн тамир, спортын салбарын 2024 оны
худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт**

Худалдан авах ажиллагааны эрх шилжсэн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр	Төсөл арга хэмжээний тоо	Мөнгөн дүн /сая.төг/	Гэрээ байгуулсан ТАХ-ний тоо	Мөнгөн дүн /сая.төг/	Биелэлт
Төрийн худалдан авах ажиллагааны газар	10	60,094.3	6	50,312.9	60%
Архангай аймгийн Засаг дарга	2	5,154.9	-	-	0%
Нийслэлийн Засаг дарга	1	19,113.3	1	18,232.5	100%
Баянхонгор аймгийн Засаг дарга	1	600.0	1	569.5	100%
Биеийн тамир спортын Улсын хороо	6	6,702.0	4	4,811.7	67%
Дүн	20	91,664.5	12	73,926.6	60%

Сүүлийн 10 жилд тус салбарт Биеийн тамир, спортын чиглэлийн 110 барилга, байгууламж барих ажилд 512,482.1 сая төгрөг улсын төсвөөс батлагдсан байна.

Эдгээр барилгын 65 объект ашиглалтад орсон, 37 объектын барилга дуусаагүй баригдаж байгаа, 8 объект царцсан байна. Мөн ашиглалтад ороогүй, барилга угсралтын ажил царцсан ажлуудыг байршилаар ангилан үзвэл:

Үйл ажиллагаа нь зогссон буюу царцсан 2024 онд улсын төсвийн тухай хуульд санхүүжилт нь тусгагдаагүй олон жил дамнан /2010-2020/ 8 барилга байгуулж байгаа бөгөөд эдгээрийг дурдвал.

1. Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 1000 суудал бүхий спорт цогцолбор /2010он/, Гүйцэтгэл 40%
2. Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт баригдах Нийслэлийн 1000 суудал бүхий спорт цогцолбор /2010 он/, Гүйцэтгэл 30%
3. Дорнод аймгийн Хэрлэн сумын Спорт цогцолборын өргөтгөл, усан бассейн /2011он/ Гүйцэтгэл 40%
4. Увс аймгийн Улаангом сумын 450 суудал бүхий спорт цогцолбор, усан бассейны барилга /2012он/ Гүйцэтгэл 70%
5. Орхон аймгийн, Баян-Өндөр сумын Баянбулаг багийн спорт заалны барилга /2018он/ Гүйцэтгэл 70%
6. Ховд аймгийн Цэцэг сумын 250 суудал бүхий спорт заалны барилга /2020 он/ Гүйцэтгэл 35%
7. Ховд аймгийн Дарви сумын 250 суудал бүхий спорт заалны барилга /2020 он/ Гүйцэтгэл 35%
8. Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт баригдах Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн /2008 он/

Мөн эдгээр ажлуудын анхны төсөөт өртгийг сүүлд батлагдсан төсөөт өртөгтэй харьцуулан шинжлэхэд 43 барилгын өртөг 109,280.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Биеийн тамир, спортын улсын хороо нь худалдан авах ажиллагааны хүрээнд урсгал засвар, харуул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээ, биеийн тамир, спортын олон улсын эрх зүйн баримт бичгийг орчуулан, эмхэтгэл гаргах, шилдэг бүтээл сонгон шалгаруулах, хяналтын камерын систем суурилуулах ажил, арга хэмжээг зохион байгуулах, тоног төхөөрөмж, программ хангамж худалдан авах зардлыг нэгдсэн журмаар 1,881.5 сая төгрөгийн төсөөтэй 19 арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөж, тайлант хугацаанд 10 ажлын тендерийг нийтэд зарлаж, 991.5 сая төгрөгийн гэрээг байгуулсан, мөн төсөөт өртөг нь 20.0 сая төгрөгөөс доош дүн бүхий 2 арга хэмжээг шууд худалдан авалтаар гэрээ хийж, нийт 1,027.5 сая төгрөгийн худалдан авалт хийж, төлөвлөгөөний биелэлт 63 хувьтай хэрэгжиж байна.

6. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ, БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ДҮН

6.1 Салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үр дүн:

“Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт Биеийн тамир, спортын салбарт 2 зорилт 14 арга хэмжээний хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр зорилтын дундаж **56.65** хувьтай.

Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 1 зорилго 1 зорилт 4 арга хэмжээнний хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр зорилтын дундаж 90 хувьтай.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 зорилго 3 зорилт 16 арга хэмжээний хэрэгжилт 2024 оны хагас жилийн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр зорилтын дундаж 59 хувьтай.

Хэрэгжилт хангалтгүй зорилтот түвшинд хүрээгүй арга хэмжээ байна. Үүнд:

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 3 зорилт 16 арга хэмжээний хэрэгжилтийн 2024 оны хагас жилийн байдлаар 2.2.2 дугаар зорилтын 1 дэх, 2.2.3 дугаар зорилтын 3.1, 3.2, 3.3, 3.4, 3.7 арга хэмжээ тус бүр Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламж, Тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадмыг зохион байгуулах шаардлага хангасан, олон улсын жишигт нийцсэн 30.000-40.000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн барих, Спортын төв ордныг барих ажлыг эхлүүлэхэд БНХАУ-ын буцалтгүй тусlamжаар шинэчлэн барих, Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор байгуулах, Нийслэлийн спортын сургалттай дунд сургууль барих спортын бүтээн байгуулалт тус тус байна.


Жич:/Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны сайд /

Энэхүү арга хэмжээний удааширсан шалтгаан санхүүжилтийн асуудлаас шийдвэрлэгдээгүй, 2 салбарын хоорондын зохион байгуулалт, хамтын ажиллагаанаас хамаарч хүндрэл учруулж эцсийн үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

6.2 Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дүн:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны хагас жилийн хэрэгжилтэд Биеийн тамир, спортын тухай хууль болон бусад 3 хуулийн 3 заалт, Улсын Их хурлын 5 тогтоол 9 заалт, Улсын Их Хурлын байнгын хорооны 4 тогтоол 13 заалт, Ерөнхийлөгчийн 3 зарлиг 4 заалт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1 зөвлөмж, Засгийн газрын 4 тогтоол 7 заалт, Засгийн газрын хуралдааны 15 тэмдэглэлийн 18 заалт, Засгийн газрын 3 албан даалгавар 3 заалт нийт 38 шийдвэрийн 58 заалт буюу “бүрэн хэрэгжсэн” 100%-ийн хэрэгжилт 43, “хэрэгжих шатанд” 70% -ийн хэрэгжилт 11, “хэрэгжилт хангалтгүй” 30%-ийн хэрэгжилт 2, “хэрэгжилт байхгүй” 2 тус тус үнэлэгдэж хэрэгжилт “бүрэн хэрэгжсэн” буюу 91.6 хувьтай хэрэгжсэн байна.

2021 оноос -2024 оны хагас жилийн ХШҮ үнэлгээ БТСУХ,
ЗГХЭГ-ийн засгийн газрын new.unelgee.gov.mn үнэлгээ график -5



6.3 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн дүн:

Биеийн тамир, спортын улсын хорооны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн баталсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд З зорилгын хүрээнд 13 зорилт 54 арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилтын дундаж **87.9** хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байна.

№	Биелэлтийн хувь	Арга хэмжээний тоо
1.	“үр дүнтэй” буюу 100 хувь	34
2.	“тодорхой үр дүнд хүрсэн” 70 – 99 хувь	9
3.	“эрчимжүүлэх шаардлагатай” 31 – 69 хувь	5
4.	“үр дүнгүй” 0- 30 хувь	6
5.	Нийт арга хэмжээ	54

2024 оны 3 дугаар улирлын байдлаар зарим арга хэмжээг тооцоо судалгаанд үндэслээгүй, хэрэгжих боломжтой хугацаа, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг оновчтой, тодорхой төлөвлөөгүй зөрчил байсаар байна.

Энэ байдлаас үүдэн төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжихгүй, дутуу хэрэгжих үр дагавар үүсэж байна. Мөн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд гарсан зөрчлийг арилгах, хамтран хэрэгжүүлэх, ажлын уялдаа холбоотой байх, ажлын хариуцлагыг сайжруулах зэрэг зөвлөмжийг хагас бүтэн жилээр өгсөн боловч зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахгүй байгаа нь тус тус харагдаж байна.

7.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Биеийн тамир, спортын салбарын төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын үр дүнд гүйцэтгэсэн дотоод аудитын дүн:

Биеийн тамир спортын салбарын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 10 зорилт 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын гүйцэтгэл нь 2024 оны III улирлын байдлаар 68,871.7 сая төгрөгийн төсвийн зарцуулалт хийж, төлөвлөгөөний хэрэгжилт 88 хувьтай дүгнэгдэв.

Улсын төсөвт батлагдсан Биеийн тамир, спортын салбарын хөрөнгө оруулалтын 20 ажлын худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг 60.0 хувьтай гэж дүгнэв.

Биеийн тамир, спортын улсын хорооны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд 7,959.6 сая төгрөгийн санхүүгийн алдаа дутагдал илэрсэн тул хөтөлбөрийн хэрэгжилтэд дотоод хяналтыг “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлт өгч байна.

Төсвийн тухай хуулийн 6.6.1-д заасны дагуу төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх зарчимтай байтал БТСУХ-ны даргын албан үргийг түр орлон гүйцэтгэгч О.Баттулга нь иргэн, хуулийн этгээдтэй ажил гүйцэтгүүлэх, дэмжлэг үзүүлэх, түрээсийн гэрээ байгуулах зэрэг 5,444.5 сая төгрөгийн 126 гэрээг өөрөө баталгаажуулаагүй, байгууллагын нэгжийн удирдлагаар батлуулж төсвийн хөрөнгийг зарцуулсан зөрчил гаргасан.

Монголын Кураш бөхийн холбоо нь Монгол Улсад Кураш бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулахад 350.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авахаар гэрээ байгуулж 300.0 сая төгрөгийн санхүүжилт авсан байтал АНУ-д болсон Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох гэсэн зориулалтаар 49.0 сая төгрөгийн санхүүжилт авсан, эдгээр тэмцээний санхүүгийн анхан шатны баримтыг бурдүүлж өгөөгүй нь төсвийн хөрөнгийг зүй бусаар ашигласан байх магадлалтай, мөн Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн зарчмыг хэрэгжүүлээгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зөрчил илэрч байгаа тул Авлигын эсрэг хуулийн 8.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй гэсний дагуу АТГ-д шилжүүлэн шалгуулах шаардлагатай гэж дүгнэв.

Дотоод аудитын дүнгээр холбогдох хууль тогтоомжийг зөрсөн тул 7.5 сая төгрөгийн нөхөн төлбөрийн 4 акт тогтоов. Үүнд:

- Сайн дурын 35 ажилтны 2 удаагийн хоолны 1.6 сая төгрөгийн зардлыг төсвөөс дахин зарцуулж батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан;
- Албан хаагчдад 3,307.3 мянган төгрөгийн цалин хөлс илүү, 601.4 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс дутуу олгосон;
- Ес зүйн дэд хорооны нарийн бичгийн даргаар ажилласан хугацааны урамшууллыг олгоходоо дэд хорооны гишүүний урамшууллыг давхардуулан тооцож 660.0 мянган төгрөгийг илүү олгосон.
- Албан томилолтоор ажиллаагүй албан хаагчдын томилолтын зардлыг томилолтоор явсан бусад ажилтны дансанд шилжүүлэн 1.3 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

Мөн холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй тул 2,507.6 сая төгрөгийн зөрчил арилгуулах 7 заалттай албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлж байна. Үүнд:

- Олон Улсын хүүхдийн Х наадмын Монголын баг тамирчдын хувцас авах 61.2 сая төгрөгийн зардлыг спортын 11 холбоонд хуваан шилжүүлж, тендер шалгаруулалт зохион байгуулаагүй, шууд худалдан авсан, төсвийн хэмнэлт 2.3 сая төгрөгийг спортын холбоод зориулалт бусаар зарцуулсан;
- Үндэсний шигшээ багийн тамирчдын хэрэглэл материалын зардалд 1,435.0 сая төгрөгийг Спортын холбоодоор дамжуулан шууд зарцуулсан нь ТБОНӨХБАУХАТ хуулийн "10.2, 10.3 гэснийг зөрчсөн байна. Цаашид биеийн тамир, спортын урсгал төсөв, хөтөлбөр арга хэмжээний төсвийг зарцуулахдаа салбарын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тухайн жилд зохион байгуулах уралдаан тэмцээн, нийтийн биеийн тамирын арга хэмжээ, улсын шигшээ багийн хэрэглэл материал худалдан авах зардал зэргийг тусгаж Тендерийн хуулийн дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажиллаж зөрчлийг арилгах;
- Илүү цагийн нэмэгдэл хөлс олгох тухай 2024 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн Б/49 дүгээр тушаалын хэрэгжилтийг шалгахад тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрүүлэн 6 ажилтанд 13 цагийн нэмэгдлийг илүү тооцож нийт 215.8 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс илүү олгосон;
- Үндэсний шигшээ багийн холбоодын санхүүжилтэд тавих дотоод хяналт сулаас Нийгмийн даатгал, татварын байгууллагад 367.1 сая төгрөгийн өр төлбөр, баг тамирчдын цалингийн бүртгэлд 134.5 сая төгрөгийн алдаа гаргасан.
- Кураш бөхийн холбоонд олгосон 349.0 сая төгрөгийн санхүүжилтийн зарцуулалтын анхан шатны баримт дутуу;
- Засгийн газрын тогтоолд батлагдаагүй Колухстил бөхийн Дэлхийн аваргын тэмцээнд 20.4 сая төгрөгийн зардал гаргасан;
- Санхүүжилтийн журамд тусгагдаагүй зардлын ангиллаар шигшээ багийн 4 тамирчны эмчилгээнд 137.9 сая төгрөгийн зардал гаргасан.

Аудитаар илэрсэн тайланд дурдсан алдаа дутагдалыг залруулах, аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж биелэлтийг цаглаварт хугацааны дотор ХШУДАГ-т албан бичгээр хавсарган ирүүлэхийг холбогдох газар, байгууллагад мэдэгдэж байна.

9. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

- БТСУХ-ны зохион байгуулалтын нэгжийн дарга О.Гэрэл, Ж.Баасансүрэн, О.Баасан, Д.Цэрэнболд нар албан тушаалын тодорхойлолтод заагдаагүй чиг үүргийг хэрэгжүүлэн 5,444.5 сая төгрөгийн 126 гэрээ байгуулан, баталгаажуулсан нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13. албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах гэсэн заалтыг зөрчсөн тул сахилгын арга хэмжээ тооцох;

- БТСУХ-ны гадаад харилцаа, мэдээлэл технологийн хэлтсийн дарга Г.Оюунбат Монголын ксиангцигийн холбооны удирдах зөвлөлийн даргаар сонгогдон Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.18-д заасны дагуу үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх нийтлэг чиг үүргийг зөрчсөн тул сахилгын арга хэмжээ тооцох;
- Дотоод аудитын хяналт шалгалтаар холбогдох хууль тогтоомж зөрчиж 7.5 сая төгрөгийн нөхөн төлбөрийн акт, 2,507.6 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага тавигдаж төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд алдаа дутагдал илэрсэн тул Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Д.Цэрэнболд, ерөнхий нягтлан бодогч А.Өнөрцэцэг нарт сахилгын арга хэмжээ тооцох;
- БТСУХ-ны Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн мэргэжилтэн Э.Ундрям нь Илүү цагийн нэмэгдэл хөлс олгох тухай тушаалыг төлөвлөж /өөртөө 24 цагийн илүү цаг тооцсон/ Төрийн албаны тухай хуулийн 37.1.13. албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах нийтлэг чиг үүргийг зөрчсөн, сайн дурын 35 ажилтны 2 удаагийн хоолны 1.6 сая төгрөгийн зардлыг төсвөөс дахин зарцуулж батлагдсан төсвийг хэтрүүлсэн тул сахилгын арга хэмжээ тооцох ;
- БТСУХ-ны хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Нармөнх нь албан хаагчдын цагийн бүртгэл, төрийн алба хаасан хугацааг үнэн зөв тооцоогүйгээс ахлах мэргэжилтэн Б-д 1,643.4 мянган төгрөгийн цалин, ахлах мэргэжилтэн С.Н, спортын мэргэжилтэн М.Г нарт төрийн алба хаасан хугацааны 474.8 мянган төгрөгийн нэмэгдлийг илүү олгосон, ээлжийн амралтын олговрыг тухайн албан хаагчийн улсад ажилласан хугацааг үнэн зөв тооцоогүй шалтгаанаар 2-оос 6 хоногоор илүү тооцож 3 албан хаагчид 1,185.1 мянган төгрөгийн цалин хөлс илүү олгосон, мэргэжилтэн М.Г-ийн ээлжийн амралтын хугацааг зөв тооцоогүйгээс 170.0 мянган төгрөгийн олговор дутуу олгогдсон зэрэг алдаа гаргасан тул сахилгын арга хэмжээ тооцох;
- БТСУХ-ны хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн С.Номин нь албан тушаалын тодорхойлолтод заагдаагүй чиг үүрэг гүйцэтгэж байгууллагын даргыг төлөөлж 5,444.5 сая төгрөгийн 126 гэрээ хэлцлийг нэгжийн дарга нар баталгаажуулсан алдаанд хяналт тавиагүй, худалдан авах ажиллагааны хууль тогтоомж зөрчиж спортын холбоотод санхүүжилт өгөх байдлаар бараа материал хөрөнгө бэлтгэх тушаал гаргахад хууль эрхзүйн ажлын байрны чиг үүргийн дагуу хяналт тавиагүй алдаа зөрчил гаргасан тул сахилгын арга хэмжээ тооцох;

**Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч О.Баттулгад**

Хугацаа

Зөвлөмж 1. Биеийн тамир, спортын хөтөлбөрийн зарцуулалтын төсвийг зардлын ангиллаар дэлгэрэнгүй боловсруулж батлуулах, гүйцэтгэлийн тайланд төсөвлөсөн зардлын зөрүүгийн шалтгаан нөхцөлд тайлбар гаргаж, батлагдсан төсвийг хэтрүүлэхгүй ажиллах.

Зөвлөмж 2. Хөтөлбөр арга хэмжээний биелэлтэд захиалагчийн хяналтыг үр нөлөөтэй тавьж дотоод хяналтыг сайжруулан, санхүүгийн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж гэрээнд заасан санхүүжилтийг урьдчилгаа болон гүйцэтгэлийн дүнгээр хувааж, тооцоо нийлсэн актаар олгож байх.

2025 оны 03-р
сарын 25-ны
дотор

Биеийн тамир, спортын улсын хорооны ерөнхий нягтлан бодогч
А.Өнөрцэцэг

Хугацаа

- Зөвлөмж 1. Ес зүйн дэд хорооны ажиллах журмын дагуу нарийн бичгийн даргаар ажилласан гишүүнд урамшууллыг давхардуулахгүйгээр олгож, үнэн зөв тайлагнаж байх;
- Зөвлөмж 2. Цагийн бүртгэл, төрийн алба хаасан хугацааг үндэслэн албан хаагчдын цалин хөлсийг тооцоолж үнэн зөв тайлагнаж байх;
- Зөвлөмж 3. Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журмын дагуу албан томилолтоор ажилласан албан хаагчийн харилцах дансанд томилолтын зардлыг олгож, үнэн зөв тайлагнаж байх;
- Зөвлөмж 4. Албан томилолтын удирдамж, үнэмлэх, томилолтын ажлын тайлан зэрэг анхан шатны баримтын бурдлийг хангаж зардлыг олгож байх;
- Албан томилолтоор ажилласан хугацаанд байгууллагаас олгодог унаа хоолны хөнгөлөлтийг олгохгүй байх;
- Зөвлөмж 5. Холбогдох албан хаагчдад журамд заасан хязгаарт багтаан илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгож байх;
- Зөвлөмж 6. Үндэсний шигшээ багийн цалин олгосон санхүүгийн баримтыг журам, зааврын дагуу бүрдүүлж, нийгмийн даатгал, татварын суутгалыг даатгалын сан, төсөвт хуульд заасан хугацаанд шилжүүлэн тайлагнасан байдалд хяналт тавьж гүйцэтгэлийн дүнгээр санхүүжилт олгож байх.

2025 оны 03-р
сарын 25-ны
дотор

2025 оны 03-р
сарын 25-ны
дотор

ХЯНАСАН:

ХШУДАГ-ЫН ДАРГА, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  Д.ТУМЭНДЭМБЭРЭЛ

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ДОТООД АУДИТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА
ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  Ц.АЛТАНХУЯГ

ТАНИЛЦАЖ ЗЭВШӨӨРСӨН:

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  О.БАТТУЛГА

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭРЭНБОЛД



МОНГОЛ УЛСЫН СОЁЛ, СПОРТ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ
**УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АКТ**

1026 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 –т заасны дагуу Биеийн тамир, спортын төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын үр дүнд гүйцэтгэсэн дотоод аудитын дүн, иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу дотоод хяналт шалгалт хийхэд дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

- Хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтнээр 7 хоног ажилласан Б.Б гэдэг албан хаагчид 4 дүгээр сард бүтэн сарын 2,410.3 мянган төгрөгийн цалин хөлс тооцож, 1,643.4 мянган төгрөгийн цалин илүү олгосон;
- Хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн С.Н, спортын мэргэжилтэн М.Г нарын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг илүү тооцож 474.8 мянган төгрөгийн нэмэгдлийг илүү олгосон;
- Ээлжийн амралтын олговрыг тухайн албан хаагчийн улсад ажилласан хугацааг үнэн зөв тооцоогүй шалтгаанаар 2-оос 6 хоногоор илүү тооцож 3 албан хаагчид 1,185.1 мянган төгрөгийн цалин хөлс илүү олгосон;
- Мэргэжилтэн М.Г-ийн долоо хоногийн амралтын өдөр ажилласан 431.4 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг олгоогүй, түүний ээлжийн амралтын 170.0 мянган төгрөгийн олговрыг дутуу олгосон.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57.1 Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалтын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно, Хөдөлмөрийн тухай хуулийн 42.1.3 гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах, 99.5 Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллаж байгаа ажилтанд түүний ажилласан хугацааг харгалзан ээлжийн үндсэн амралтын хугацаан дээр нь дараах нэмэгдэл амралт олгоно, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалаар баталсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 2.13.Ажилтны ажилласан хугацааг харгалзан ээлжийн нэмэгдэл амралтыг дор дурдсанаар тооцож олгоно гэсэн гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.12.2-д заасан аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж улсын орлого болгох, түүнчлэн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нэр бүхий албан хаагчдад цалин хөлс, нэмэгдэл, ээлжийн амралтын олговрыг илүү олгосон тул 3,307.3 мянган төгрөгийг суутган байгууллагын 100900034033 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Мэргэжилтэн М.Гэрлээд долоо хоногийн амралтын өдөр ажилласан 6 хоногийн 431.4 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс, 2 хоногийн ээлжийн амралтын 170.0 мянган төгрөгийн олговрыг нөхөн тооцож олгох;

Актын биелэлтийг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд ирүүлэх;

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Баттулга, ерөнхий нягтлан бодогч А.Өнөрцэцэг нар хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН ХЯНАДАГ ШАЛТАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАНХУЯГ



02 дугаар актын хавсралт

Албан хаагчдын ээлжийн амралтын олговор шалгасан дүн

№	Албан хаагчдын нэрс	Улсад ажилласан хугацаа	Хөдөлмөрийн хуулийн дагуу ногдох амралтын хоног	Ээлжийн амралт олгосон хоног	Амралтын олговор	Илүү олгосон амралтын олговор	Дутуу олгосон амралтын олговор
1	А.Рита	22 жил	24	26	2,747.2	211.3	-
2	Г.Эрдэнэцогт	14 жил	20	24	2,839.0	473.2	-
3	Д.Есөнчимэг	3 жил	18	24	2,002.4	500.6	-
4	М.Гэрлээ	11 жил	20	18	1,530.4	-	170.0
	Дүн					1,185.1	170.0

Мэргэжилтэн М.Гэрлээгийн илүү цагийн нэмэгдэл хөлс тооцсон дүн

	Үндсэн цалин	Ажилласан цаг	нэг цагт ногдох	Илүү цаг	Илүү цагийн нэмэгдэл хөлс	журамд заасан цагийн хязгаарлалт	Илүү цагийн нэмэгдэл хөлс
6-р сар	1,452.0	152	10	32	458.5	15	217.8
7-р сар	1,452.0	152	10	8	114.6	8	114.6
8-р сар	1,452.0	176	8	8	99.0	8	99.0
					672.2		431.4

Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шалгасан дүн

№	Албан хаагчдын нэрс	Төрийн алба хаасан хугацаа	Илүү тооцсон хувь	Илүү олгосон нэмэгдэл
1	С.Номин	8-аас 9 жил	1-2 хувь	316.4
2	М.Гэрлээ	8 жил	1-2 хувь	158.4
	Дүн			474.8

Шалгасан: Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч, шинжээч Ц.Алтанхуяг



оे дугаар актын хавсралт

БТСУХ-ны хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Батгаа овогтой Баттогоход 4-р сард олгосон цалинг дахин
шалгасан тооцоолол

№	Үндсэн цалин	Бодогдсон цагин	Алба хаасан хугацааны нэмэгдэл	Зэргийн нэмэгдэл	Хоолны хөнгөлөлт ийн дүн	Нийтийн тээврийн унааны хөнгөлөлт ийн дүн	Нийт бодогдсон дүн	НДШ	ХХОАТ	Урьдчилгаа цалин	Нийт гарг олгох дүн
1	1,597.0	22	22	1,597.0	63.9	287.5	440.0	22.0	2,410.3	277.2	201.3
2	1,597.0	22	7	508.1	20.3	91.5	140.0	7.0	766.9	88.2	49.9
	Зөрүү								1,643.4		200.0
											1,303.0



Шалгасан: Санхүүгийн хяналт шатгалтрын
Улсын ахлах байцаагч, шинжээч
[Signature] Ц.Алтанхүяг



МОНГОЛ УЛСЫН СОЁЛ, СПОРТ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ
**УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АКТ**

2025 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 –т заасны дагуу Биеийн тамир, спортын төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын үр дүнд гүйцэтгэсэн дотоод аудитын дүн, иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу дотоод хяналт шалгалт хийхэд дараах зөрчил, дутагдал илэрлээ.

Үүнд:

- Ес зүйн дэд хорооны гишүүн Б.Лхагваниам, С.Мөнх-Эрдэнэ нарт нарийн бичгийн даргаар ажилласан хугацааны урамшууллыг олгоходо дэд хорооны гишүүний урамшууллыг давхардуулан тооцож 660.0 мянган төгрөгийг илүү олгосон.

Энэ нь Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Ес зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 3.8-д заасан 5 болон 7 хүний бүрэлдэхүүнтэй Дэд хорооны нарийн бичгийн даргад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг сар бүр, дарга, гишүүдэд хурал болон бусад арга хэмжээнд оролцсон ирц, идэвх оролцоог харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож, улиралд нэг удаа урамшуулал олгоно гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.12.2-д заасан аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж улсын орлого болгох, түүнчлэн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Урамшууллыг илүү олгосон тул 660.0 мянган төгрөгийг байгууллагын 100900034033 тоот дансанд төвлөрүүлэх, биелэлтийг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд ирүүлэх;

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Баттулга, ерөнхий нягтлан бодогч А.Өнөрцэцэг нар хариуцуулав.

ТЕЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАНХУЯГ



02 дугаар актын хавсралт

**БТСУХ-ЫН ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшуулал
олгосон тооцоог дахин шалгасан дүн**

Нэрс	Ес зүйн дэд хорооны	Гишүүний урамшуулал	НБД-ын урамшуулал	Нийт олговол зохих урамшуулал	Олгосон урамшуулал	Зөрүү /- илүү/
Д.Цэрэнболд	Дарга	660.0	-	660.0	660.0	-
С.Мөнх- Эрдэнэ	Гишүүн	440.0	330.0	770.0	990.0	220.0
Б.Лхагваниам	Гишүүн	220.0	660.0	880.0	1,320.0	440.0
Ш.Баясгалан	Гишүүн	660.0	-	660.0	660.0	-
С.Номин	Гишүүн	660.0	-	660.0	660.0	-
		2,640.0	990.0	3,630.0	4,290.0	660.0

Шалгасан: Санхүүгийн хяналт шалгалтын
Улсын ахлах байцаагч, шинжээч 

11-02



МОНГОЛ УЛСЫН СОЁЛ, СПОРТ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ
**УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АКТ**

2025 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 –т заасны дагуу Биеийн тамир, спортын төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын үр дүнд гүйцэтгэсэн дотоод аудит, иргэнээс ируулсэн гомдолд хийсэн дотоод хяналт шалгалтаар дараах зөрчил, дутагдал илрэлзээ. Үүнд:

- Архангай аймагт 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 05-ны өдөр зохион байгуулагдсан Улсын зөвлөгөөнд оролцохоор томилогдсон 6 албан хаагч оролцоогүй байхад томилолтын зардлыг нь бичиг хэргийн ажилтан Д.Мөнгөнцэцэг, нярав ажилтай Б.Болдтөр нарын харилцах дансанд шилжүүлж 3,260.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-ын 2.6. Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчид томилолтоор ажиллуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр, батлагдсан зардлын төсвийг үндэслэн томилолтоор ажиллах үеийн нөхөн төлбөрийг урьдчилан олгоно гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.12.2-д заасан аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж улсын орлого болгох, түүнчлэн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Албан томилолтын зардлыг зориулалт бусаар зарцуулсан тул буруутай албан тушаалтнаас 1,260.0 мянган төгрөгийг суутган байгууллагын 100900034033 тоот дансанд төвлөрүүлэх, биелэлтийг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд ирүүлэх,

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан Үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Баттулга/, өрөнхий нягтлан бодогч /А.Өнөрцэцэг/ нар хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ,
ШИНЖЭЭЧ ЦАЛТАНХУЯГ





МОНГОЛ УЛСЫН СОЁЛ, СПОРТ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ
**УЛСЫН БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 –т заасны дагуу Биеийн тамир, спортын төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын үр дүнд гүйцэтгэсэн дотоод аудит, иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу шалгасан дотоод хяналт шалгалтаар дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

- Олон Улсын хүүхдийн Х наадмын Монголын баг тамирчдын хувцас авах 61.2 сая төгрөгийн зардлыг спортын 11 холбоонд хуваан шилжүүлж, тендер шалгаруулалт зохион байгуулаагүй, шууд худалдан авсан, төсвийн хэмнэлт 2.3 сая төгрөгийг спортын холбоод зориулалт бусаар зарцуулсан;
- Үндэсний шигшээ багийн тамирчдын хэрэглэл материалын зардалд 1,435.0 сая төгрөгийг Спортын холбоодор дамжуулан шууд зарцуулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 10.2, 10.3 гэснийг зөрчсөн;
- Илүү цагийн нэмэгдэл хөлс олгох тухай 2024 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн Б/49 дүгээр тушаалтын хэрэгжилтийг шалгахад тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрүүлэн 6 ажилтанд 13 цагийн нэмэгдлийг илүү тооцож нийт 215.8 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс илүү олгосон;
- Үндэсний шигшээ багийн холбоодын санхүүжилтэд тавих дотоод хяналт сулаас Нийгмийн даатгал, татварын байгууллагад 367.1 сая төгрөгийн өр төлбөр, баг тамирчдын цалингийн бүртгэлд 134.5 сая төгрөгийн алдаа гаргасан.
- Кураш бөхийн холбоонд олгосон 349.0 сая төгрөгийн санхүүжилтийн зарцуулалтын анхан шатны баримт дутуу;
- Засгийн газрын тогтоолд батлагдаагүй Колухстил бөхийн Дэлхийн аваргын тэмцээнд 20.4 сая төгрөгийн зардал гаргасан;
- Санхүүжилтийн журамд тусгагдаагүй зардлын ангиллаар шигшээ багийн 4 тамирчны эмчилгээнд 137.9 сая төгрөгийн зардал гаргасан.

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 10.2, 10.3, Төсвийн тухай хуулийн 6.4.1, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21.1, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25.1.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3.1, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан

"Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам"-ын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9.8-д хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанда шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Биеийн тамир, спортын урсгал төсөв, хөтөлбөр арга хэмжээний төсвийг зарцуулахдаа салбарын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тухайн жилд зохион байгуулах уралдаан тэмцээн, нийтийн биеийн тамирын арга хэмжээ, улсын шигшээ багийн хэрэглэл материал худалдан авах зардал зэргийг тусгаж тендерийн хуулийн дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажиллаж зөрчлийг арилгах;
2. Илүү цагийн нэмэгдэл хөлсийг хууль тогтоомжид нийцүүлэн олгож байх;
3. Үндэсний шигшээ багийн холбоодын санхүүжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулан НДШ, Татварын өр төлбөрийг барагдуулах;
4. Засгийн газрын шийдвэр гараагүй Олон улсын тэмцээнд төсөв хөрөнгө зарцуулахгүй байх;
5. Үндэсний шигшээ багийн санхүүжилт олгох журамд заагдаагүй зардлын ангиллаар төсөв зарцуулахгүй байх.

Зөрчлийг арилгаж биелэлтийг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор ССАЖЗ-ын яаманд ирүүлэх;

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (О.Баттулга), ерөнхий нягтлан бодогч (А.Өнөрцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ТАВЫСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ
ШИНЖЭЭЧ  ЦАЛТАНХУЯГ

АЛБАН ШААРДЛАГЫГ ХҮЛЭЭН АВСАН:

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ О.БАТТУЛГА

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

А.ӨНӨРЦЭЦЭГ